

Улсын бүртгэлийн
дугаар:

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШУСс-2017/47

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

«МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ҮЙЛ ЯВЦЫН ХӨГЖИЛД УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ»

Суурь судалгааны төслийн тайлан

2017-2019

Гүйцэтгэгч:

ШУА-ийн Философийн хүрээлэн

Удирдагч:

Дугаржавын Баасансүрэн, доктор (Ph.D)
Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч

Санхжүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Тайлан өмчлөгч:

ШУА-ийн Философийн хүрээлэн
Улаанбаатар хот 15141, Чингэлтэй дүүрэг, Баруун Сэлбийн
гудамж-15, ШУА-ийн Хүрээлэнгүүдийн нэгдсэн II байр.
Шуудангийн салбар 38, Шуудангийн хайрцаг-266
Э-хаяг: info@ip.ac.mn
Утас: 33-08-46; 33-08-47
Факс: (976)-11-33-08-46

Улсын бүртгэлийн
дугаар:

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШУСс-2017/47

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

«МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ҮЙЛ ЯВЦЫН ХӨГЖИЛД УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ»

Суурь судалгааны төслийн тайлан

2017-2019

Гүйцэтгэгч:

Ойдовын Хатанболд, ЭШДэА, доктор (Ph.D)

Аюушийн Хишигдаваа, ЭШДэА, магистр

Цогтсайханы Жаргал, ЭШДэА, магистр

Мэндбаярын Долгорсүрэн, ЭШДэА, магистр

Цэнджавын Баянмөнх, ЭШДаА, магистр

Болд-Эрдэнийн Мягмарцэрэн, ЭШДаА, магистр

Дэлгэрийн Энхболд, магистр

Төслийн гэрээт ажилтан

Даваадоржийн Номун-Эрдэнэ, магистр

Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбарын ЭШДэА

Дагвын Болд-Эрдэнэ, ЭШТА, доктор (Sc.D), профессор

Намсрайн Баяр, ЭШАА, магистр

Захиалагч байгууллага: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Санхүүжүүлэгч байгууллага: Шинжлэх ухаан, технологийн сан

Тайлан өмчлөгч: ШУА-ийн Философийн хүрээлэн

Улаанбаатар
2019

РЕФЕРАТ

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн улс төр, эрх зүйн салбараас 2017-2019 онд «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» суурь судалгааны төслийг хэрэгжүүлсэн болно.

Улс төрийн соёлын талаар судалгаа хийхийн тулд түүний талаар ядахдаа ажлын тодорхойлолттой байх хэрэгтэй. Түүнчлэн улс төрийн соёлын нийгэмд гүйцэтгэдэг үүргийг тодорхойлж тодорхой үзүүлэлтээр хэмжих хэрэгтэй байдаг. Улс төрийн шинжлэх ухааны салбарт хийсэн судалгааны үр дүнд улс төрийн соёл гэж юу болох тухай онолын үзэл баримтлал, тодорхойлолт олон гарсан байдаг. Эдгээр тодорхойлолтын хувьд ерөнхийд нь ангилан үзэхүл өргөн ба явцуу гэсэн хоёр ангид хувааж болох юм. Өргөн ангилалд багтах тодорхойлолтууд нь иргэдийн улс төрийн мэдлэг, үнэлэмж, хандлага, үйл ажиллагааны загвар, улс төрийн байгууллагууд, хууль тогтоомж гэх мэт маш олон зүйлийг хамруулан тоочсон тодорхойлолтууд байдаг. Ийм тодорхойлолтууд нь чухам яг улс төрийн соёл гэдэг үзэгдлийн мөн чанарыг бүдгэрүүлэх учраас судалгаанд ашиглах боломжгүй гэж үзэж байна.

Суурь судалгааны төслийн хүрээнд улс төрийн соёл бол хүн төрөлхтний нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн соёлын хүрээ бөгөөд улс төр, улс төрийн үйл ажиллагаа, хүмүүсийн зан байдал, ухамсартай шууд холбоотой юм. Улс төрийн соёлыг улс төрийн чиг баримжаа, хувь хүн, жижиг, том бүлгүүдийн улс төрийн зан төлөв, төлөвшилд нөлөөлдөг үндэсний буюу үндэстэн дамнасан нийгэмлэгийн түүхэн болоод нийгмийн баялаг туршлага хэмээн ойлгодог.


Нөгөөтээгүүр, орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан улс төрийн соёлын талаарх мэдлэгийг системчилсэнээр улс төрийн чиг баримжаа, хувь хүний хандлага, зан үйлийн талаарх олон нарийн тайлбаруудыг тодорхойлох; хоёрдугаарт улс төрийн бодлоготой холбоотой нийгмийн ерөнхий соёлын элементийг ойлгоход чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, аливаа улс үндэстэн оршин тогтнож, хөгжих явцдаа оюуны болон биет асар их өвийг бий болгож, улмаар хойч үе нь залгамжлан авч явдаг. Олон үндэстний соёл дотроос оюуны соёл маш чухалд тооцогддог бөгөөд анх философи сэтгэлгээний хүрээнд боловсорсон түүхтэй ажгуу.

«Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» хэмээх энэхүү суурь судалгааны төслийн зорилго нь Монгол Улс дахь ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, тэдний улс төрийн ухаалаг сонголт хийхэд нь туслах зорилготой. Тус төсөл нь 1990-ээд оноос хойших иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, энэ хүрээн дэх сорилт, бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулах, иргэдийн улс төрийн соёлыг төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, энэ хүрээний хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулснаараа онцлогтой.

Тухайлбал, манай орны хувьд соёлыг зарим судлаачид уламжлалтай холбож нийгмийн өв гэж үздэг бол нөгөө хэсэг нийгмийн амьдралыг тодорхойлох хэм хэмжээ гэж тодорхойлсон байдаг.

Бид, «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» суурь судалгааны төслийг хэрэгжүүлэх (2017-2019) хугацаанд гүйцэтгэх үр дүнгийн даалгаварын хүрээнд нийт 144 бүтээгдэхүүнийг нийлүүлсэн. Тэдгээрийг дараах зургаар харуулж байна.

Зураг 1. Үр дүнгийн даалгаварын хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн
(ангилал бүрээр)



Түлхүүр үг:

Улс төрийн соёл, соёл, төлөвшил, улс төр, улс төрийн үйл ажиллагаа, үйл явц, хувь хүний зан төлөв, нийгмийн туршлага, иргэдийн улс төрийн оролцоо, уламжлал.

Гарчгийн мэдүүлэг

РЕФЕРАТ	2
Оршил.....	6
Нэг. Үндсэн хэсэг.....	10
1. Суурь судалгааны төслийн зорилго, үндэслэл, хэрэгцээ шаардлага, ач холбогдол	10
Суурь судалгааны төслийн зорилго	10
Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага	11
Суурь судалгааны төслийн нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол	11
Суурь судалгааны төслийн ач холбогдол	11
Хоёр. Улс төрийн соёлын тухай судалгааны үзэл баримтлал.....	12
Сэдвийн судлагдсан байдал	16
Судалгааны онол арга зүйн үндэс	17
Судалгааны арга зүй, аргачлал	18
Гурав. Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ажил, явцын үр дүн, үр дүнгээс гарсан дэвшилтэт талууд	21
Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ажлууд	23
Дөрөв. Суурь судалгааны төслийн үр дүнд суурилсан дүгнэлт	26
Тав. Суурь судалгааны төслөөс гарсан санал, зөвлөмж	29
Хавсралт 1. “Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” Суурь судалгааны төслийн үр дүнгийн даалгавар	32
Хавсралт 2. “Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” Суурь судалгааны төслийн үр дүнгийн даалгаврын дагуу хэвлэн нийтлүүлсэн бүтээлийн хураангуй танилцуулга	35
Хавсралт 3. «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» Суурь судалгааны төслийн үр дүнг олон нийтэд түгээсэн байдал	38
Хавсралт 4. Суурь судалгааны төслийн гүйцэтгэх ажлын календарьчилсан төлөвгөөний хүрээнд 2019 онд хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (Төслийн гүйцэтгэгч тус бүрээр)	40
Хавсралт 5. Суурь судалгааны төслийн гүйцэтгэх ажлын календарьчилсан төлөвгөөний хүрээнд 2018 онд хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (Төслийн гүйцэтгэгч тус бүрээр)	132

Хавсралт 6. Суурь судалгааны төслийн гүйцэтгэх ажлын календарьчилсан төлөвгөөний хүрээнд 2017 онд хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (*Төслийн гүйцэтгэгч тус бүрээр*) 168

Оршил

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны захиалгаар Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт хэрэгжсэн «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» (2017-2019) хэмээх энэхүү суурь судалгааны төслийн зорилго нь Монгол Улс дахь ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, тэдний улс төрийн ухаалаг сонголт хийхэд нь туслах зорилготой. Эл төсөл нь 1990-ээд оноос хойших иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, энэ хүрээн дэх сорилт, бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулах, иргэдийн улс төрийн соёлыг төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, энэ хүрээний хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулах явдал байв.

Нөгөө талаар, иргэд улс төрийн соёлын талаар шинжлэх ухааны үндэстэй зохих мэдлэг боловсрол эзэмшихэд нь тус дэм үзүүлснээр Монголын улс төрийн амьдрал, үйл явцын мөн чанарыг зөв бодитой ойлгож төсөөлөх болон сонголт хийх чадвар дээшлэх учиртай. Түүнчлэн улс төрийн оролцооны хууль ёсны хэлбэрийг зохистой хэрэгжүүлэх соёлд суралцах, улс төрийн шийдвэр хэрэгжих боломж дээшилж, ардчилсан тогтолцоо төлөвших, иргэний нийгэм бэхжих зэрэгт эергээр нөлөөлөх үр дүн гаргах болно. Иргэдийн улс төрийн ухамсар, соёл, ёс суртахуун дээшлэн, тэдний улс төрийн зөв сонголт хийх, ардчиллыг бэхжүүлэх, улс төрийн идэвхтэй оролцоог хэрэгжүүлэх үйл явцыг боловсронгуй болгох ач холбогдолтой юм. Тодруулбал, иргэдийн ухамсарт ардчиллын үзэл санааны үнэт зүйлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, анархизм руу чиглэсэн үйлдлүүдийг хууль эрх зүйн зохистой бодлогоор хазаарлан барих явдал нийгмийн сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх ач холбогдолтой. Улс төрийн үйл явцад оролцож буй субъектуудын улс төрийн соёлын төлөвшил нь үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх, төрт ёсоо хүндэтгэх, ардчилал шударга ёсыг бэхжүүлэхэд чухал хүчин зүйл болж буйгаараа ихээхэн анхаарал татаж буй юм. Энэ бүхэн улс төрийн соёлын төлөвшлийн үйл явцыг тусгайлан судлах шаардлага хэрэгцээг нөхцөлдүүлдэг жамтай.

Энэ утгаараа, нүүдлийн иргэншил бүхий Монголчуудыг «бүдүүлэг», «зэрлэгүүд» байсан мэтээр ярьж бичдэг тал бийг утгаа тэд соёлын тэр дундаа улс төрийн соёлын онцлог хэрнээ аугаа уламжлалтай ард түмэн билээ. Монголчууд бидний уламжлалт улс төрийн соёл нь тал нутагтаа нүүдэллэн мал сүргээ адгуулан аж төрж, төр улсаа төвхнүүлж ирсэн түүхэн үйл явцтай нягт холбоотой байснаараа өрнийн суурин иргэншил соёлоос ялгагддаг. Монгол хүн аливаад хэрсүү холч ухаанаар уужуу тайван ханддаг, эв эеийг эрхэмлэдэг, төрд хандах хандлага нь тогтсон үнэт зүйлс-ёс суртахууны үнэлэмж бүхий байжээ гэж хэлж болно. Монголчуудын төр ёсны сэтгэлгээ тал нутгийн нүүдэлчдийн сэтгэхүй, үзэл бодол, хамтран аж төрөх, ёс заншлаас уг сурвалжтай билээ. Монголчуудын улс төрийн соёлын илэрлийн нэг онцлог нь ёс суртахуун, зан заншил

нүүдэлчдийн хамтаар аж төрөх өвөрмөц байдлаас үүдсэн хамтач харилцааг зохицуулах үнэлэмж юм. Эдүгээ цагт монголчуудын уламжлалт нүүдлийн соёл, суурин соёлын хүчтэй түрэлтэнд орж, нийслэл Улаанбаатар хотдоо хүн амын бараг тал хувь нь ажиллаж амьдарч байна. Монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлт хувьслын сонирхолтой үедээ ороод байна. Үүнтэй уялдан улс төрийн соёлын хүрээнд шийдвэрлэж хариу өгвөл зохих олон асуудал хуримтлагдаж байна. Иймд иргэдийн улс төрийн соёлын өөрчлөлт, шинэчлэлт, төлөвшлийн хүрээний асуудлыг нарийвчлан судлаж хариу өгөх нь нэн чухал билээ.

Дээр дурдсан агуулгын хүрээнд төслийн судалгааны багийн гүйцэтгэгчид «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» (2017-2019) суурь судалгааны төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын үр дүнг дараах байдлаар товчоолон тайлагнаж байна.

1. Монгол Улс дахь ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг улс төрийн ухаалаг сонголт хийхэд нь туслах зорилгоор иргэдийн ухамсарт ардчиллын үзэл санааны үнэт зүйлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, анархизм руу чиглэсэн үйлдлүүдийг хууль эрх зүйн зохистой бодлогоор хазаарлан барих явдал нийгмийн сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх хүчин зүйлийг үндэсний хэмжээнд санамсаргүй түүврийн аргаар зохион байгуулсан социологийн судалгаагаар үр дүнг тодорхойлсон.
2. Улс төрийн соёлыг төлөвшүүлэгч гол институциудын нөлөөлөл сөрөг, төлөвшөөгүй байгаа тул гол институц болох улс төрийн намын санхүүжилт, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлыг хангаж, хариуцлагатай хэвлэл мэдээллийг болгох, төрийн байгууллагууд, түүний албан тушаалтнуудад тооцох хариуцлагыг эрчимтэй болгох ажлыг нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай болохыг өндөр төвшний шинжээчид дэвшүүлэн гаргасан. Энэ нь нийгмийн давхраа бүрийн улс төрд хандах хандлагыг тодорхойлох, ардчилсан нийгмийн тогтвортой байх чухал нөхцлийн нэг болох монголын улс төрийн соёлын хэв маягчлалыг тодорхойлсон нь энэхүү үнэлгээний гол үр дүн юм.
3. Суурь судалгааны төслийн эцсийн үр дүн бол «Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе» хэмээх хамтын бүтээлийг гаргах явдал юм. Эл хамтын бүтээлд 1990-ээд оноос хойших иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, энэ хүрээн дэх сорилт, бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулснаараа онцлогтой. Түүнчлэн иргэдийн улс төрийн соёлыг төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, энэ хүрээний хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулах явдал байв. Энэ хүрээнд Монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлт хувьсалтай уялдуулан улс төрийн соёлын хүрээн дэх иргэдийн улс төрийн соёлын өөрчлөлт, шинэчлэлт, төлөвшлийн хүрээний асуудлыг нарийвчлан судалж хариу өгөх

- зорилгоор «Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе» (Уб., 2020) сэдэвт хамтын бүтээлийг суурь судалгааны төслийн үр дүн болгон туурвиж хэвлүүлсэн.
4. «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» сэдэвт суурь судалгааны хүрээнд «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд үзүүлэх эдийн засаг, засаглалын зохистой нөлөөллийн асуудал» сэдэвт бичил судалгааны товхимол (Уб., 2019)-ыг боловсруулан гаргасан.
 5. Монголын нийгмийн улс төрийн соёлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг тодруулж, улмаар улс төрийн соёлын талаарх орчин үеийн онолд тулгуурлан дүгнэлт гаргах, таамаглалаа шалгах, онолын шинжтэй шинэ санаа дэвшүүлэн эл зорилгоо батлах үүднээс олон нийтийн болон шинжээчдийн судалгаа, чанарын судалгааг зохион байгуулж үр дүнг нэгтгэсэн «Өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага» (Уб., 2019) иж бүрэн судалгаа (олон нийтийн санаа бодлын, шинжээчдийн болон чанарын судалгаа)-ны тайланг боловсруулан гаргасан болно.
 6. Төслийн багийн гишүүн, ЭШДЭА, доктор (Ph.D) О.Хатанболд «Монгол дахь ардчиллын мөн чанар, төлөвших үйл явцын онцлог» (тус бүр 400 нүүр, 3 хэсэгтэй 34.5-35 хх, Уб, 2019) Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл I, II ботийг хэвлүүлэн гаргасан. Бүтээл нь Монгол оронд өрнөсөн ардчиллын үйл явцаар манай нийгэмд улс төрийн үзэл бодол, иргэний ашиг сонирхол, улс орноо хөгжүүлэхэд оролцох арга хэлбэр зэргээрээ ялгаа бүхий нийгмийн бүлгүүд үүсэн бий болсноороо монголчууд өөрсдийн үзэл баримтлал, итгэл үнэмшлээ дагасан улс төрийн үйл ажиллагаа явуулах, олон намын тогтцолоо цоо шинээр бүрэлдэн тогтох чухал үйл явцын эхлэлийг тавьсан юм. Энэ үйл явцын тусгал болж түүнтэй нягт холбоотойгоор монголын нийгмийн улс төрийн амьдралд олон ургальч ардчиллын хэлбэр хөгжиж, ардчилсан үйл явцын өрнөл, нийгмийн улс төрийн амьдралын шинэчлэл, өөрчлөлтийн агуулгыг тодорхойлох болсон.
 7. Суурь судалгааны төслийн эхний шатанд төслийн багийн үндсэн гишүүн, Улс төр, эрх зүйн салбарын ЭШДЭА, доктор (Ph.D) О.Хатанболд «Ардчилал судлал: онол, арга зүй» (Уб, 2017) нэг сэдэвт бүтээлийг туурвисан. Бүтээл 3 бүлэг, 11 зүйлээс бүтсэн, нийт 180 нүүр, 14.75 хх бөгөөд бүтээлд ардчилал бол бидний ихэвчлэн бодож төсөөлдөг шиг зөвхөн тухайн улс эсвэл төр засгийн хүрээнд хамаатай зүйл биш бөгөөд гагцхүү ардчилсан зарчмууд нь аль ч төрлийн эвлэл холбооноос хамтын шийдвэр гаргахтай холбоотой байдгыг тодорхойлохыг хичээсэн.
 8. Улс төр, эрх зүйн салбарын ЭШДЭА, доктор (Ph.D) О.Хатанболд «Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр» (Уб, 2017) нэг сэдэвт бүтээлийг туурвисан бөгөөд бүтээл 3 бүлэг 8 зүйлээс бүртсэн, нийт 170 нүүр, 14.16 хх болно. Бүтээл бүхэлдээ монголын нийгмийн өөрчлөлтийн сонирхолтой мөртлөө ээдрээтэй асуудал болох ардчилал, ардчиллын төлөвшил, түүнд гарсан өөрчлөлтийг чиглэл болгон сонгож, эл нарийн төвөгтэй үзэгдэл үйл явцын

талаарх ойлголт, хандлагыг өөрийн судалгааны хүрээнд ардчиллын онолын болоод практикийн харьцуулсан судалгааны аналитик шинжилгээг ардчиллыг сонирхон судлагчид, их дээд сургуулиудын магистр, докторантурт суралцагчид болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг бүгдэд зориулан үр дүн болгон хэвлүүлсэн.

Нэг. Үндсэн хэсэг

1. Суурь судалгааны төслийн зорилго, үндэслэл, хэрэгцээ шаардлага, ач холбогдол

Улс төрийн соёлын талаар судалгаа хийхийн тулд түүний талаарх наад захын ажлын тодорхойлолттой байх хэрэгтэй. Түүнчлэн улс төрийн соёлын нийгэмд гүйцэтгэдэг үүргийг тодорхойлж, тодорхой үзүүлэлтээр хэмжих хэрэгтэй байдаг. Улс төрийн шинжлэх ухааны салбарт хийсэн судалгааны үр дүнд улс төрийн соёл гэж юу болох тухай онолын үзэл баримтлал, тодорхойлолт олон гарсан юм. Тиймээс, бид судалгааны эрх ашгийн үүднээс шинжлэх ухааны янз бүрийн дэг сургуулийн судалгаа, тодорхойлолтыг авч үзэж харьцуулахгүйгээр улс төрийн шинжлэх ухааны хүрээгээр хязгаарлаж, улс төрийн соёлд юуг хамруулан үзэж болохыг нэрлэвэл судлах зүйл тодорхой болно хэмээн үзэж дараах томъёоллоор гурвалсан судалгааны аргаар улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлохыг оролдсон болно. Тухайлбал,

1. иргэдийн улс төрийн мэдлэг.
2. Улс төрийн үнэлэмж
3. Төр, улс төрийн байгууллагын үйл ажиллагаа, улс төрийн үйл явдлын талаарх үнэлгээ
4. Улс төрийн хүрээ, үйл ажиллагааны үе дэх зан үйл зэргийг хамруулан үзэж болох юм.

Улс төрийн соёлыг ийм бүрэлдэхүүнтэйгээр авч үзэх нь хүмүүсийн улстөрд хандах байдал болон улс төрийн үйл ажиллагааны оролцогч болохын хувьд ямар дүр төрхтэй вэ гэдгийг тодорхойлох боломж олгоно. Улс төрийн соёл нь соёл хэмээх ойлголтод багтах учир соёлын нийгмийн үүргийг гүйцэтгэж байдаг нь ойлгомжтой.

Суурь судалгааны төслийн зорилго

«Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» хэмээх энэхүү суурь судалгааны төслийн зорилго нь Монгол Улс дахь ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, тэдний улс төрийн ухаалаг сонголт хийхэд нь туслах зорилготой. Тус төсөл нь 1990-ээд оноос хойших иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, энэ хүрээн дэх сорилт, бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулах, иргэдийн улс төрийн соёлыг төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, энэ хүрээний хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулах явдал байв.

Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага

- ❖ Улс төрийн соёл бол улс төрийн шинжлэх ухааны тулгуур асуудал бөгөөд өрнөдийн зарим томоохон судлаачид ардчиллын эцсийн хамгийн бодит хэмжүүр нь улс төрийн соёлын төлөвшил хэмээн үздэг.
- ❖ Соёлын элементийг агуулаагүй улс төр, нийгмийн ямар нэг үзэгдэл, үйл явц гэж байдаггүй.
- ❖ Нүүдлийн иргэншил бүхий Монголчууд соёлын тэр дундаа улс төрийн соёлын онцлог уламжлалтай ард түмэн.
- ❖ Эдүгээ цагт монголчуудын уламжлалт нүүдлийн соёл, суурин соёл болон улс төрийн соёлын хүрээнд шийдвэрлэж хариу өгвөл зохих олон асуудал хуримтлагдсан.
- ❖ Иймд иргэдийн улс төрийн соёлын өөрчлөлт, шинэчлэлт, төлөвшлийн хүрээний асуудлыг нарийвчлан судалж хариу өгөх нь нэн чухал юм.

Суурь судалгааны төслийн нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол

Эл судалгааг хэрэгжүүлэх, судалгааны мэдээллийн үндсийг бүрдүүлэх гол туршилт сорилтын түшиц бааз нь иргэд, иргэний нийгэм, улс төрийн нам, төрийн болон орон нутгийн байгууллага байсан болно.

Суурь судалгааны төслийн ач холбогдол

Иргэдэд улс төрийн соёлын талаар шинжлэх ухааны үндэстэй зохих мэдлэг боловсрол зэмшихэд нь тус дэм үзүүлснээр монголын улс төрийн амьдрал, үйл явцын мөн чанарыг зөв бодитой ойлгож төсөөлөх болон сонголт хийх чадвар дээшлэх учиртай. Түүнчлэн улс төрийн оролцооны хууль ёсны хэлбэрийг зохистой хэрэгжүүлэх соёлд суралцах, улс төрийн шийдвэр хэрэгжих боломж дээшилж, ардчилсан тогтолцоо төлөвших, иргэний нийгэм бэхжих зэрэгт эерэгээр нөлөөлөх үр дүн гаргах болно. Иргэдийн улс төрийн ухамсар, соёл, ёс суртахуун дээшлэн, тэдний улс төрийн зөв сонголт хийх, ардчиллыг бэхжүүлэх, улс төрийн идэвхтэй оролцоог хэрэгжүүлэх үйл явцыг боловсронгуй болгоход ач холбогдолтой. Иймээс эл хэрэгцээ шаардлагыг удирдлага болгон:

- ❖ Улс төрийн соёлын талаарх онол, практикийн олон талт асуудлыг судалгааны эргэлтэд оруулах;
- ❖ Улс төрийн соёлын талаарх онол, үзэл баримтлалын оновчтой хувилбарыг санал болгох;
- ❖ Иргэдийн улс төрийн соёлыг дээшлүүлэх, ухамсартай, ёс зүйтэй, боловсролтой иргэдийг төлөвшүүлэх боломжит арга замын зохистой хувилбарыг судлан боловсруулах;
- ❖ Улс төрийн соёлын талаарх социологи, нийгмийн сэтгэл зүйн судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх;
- ❖ Судалгааны үр дүнгээр хамтын бүтээл гаргах зорилт тавьж ажилласан болно.

Хоёр. Улс төрийн соёлын тухай судалгааны үзэл баримтлал

Улс төрийн шинжлэх ухааны салбарт хийсэн судалгааны үр дүнд улс төрийн соёл гэж юу болох тухай онолын үзэл баримтлал, тодорхойлолт олон байдаг. Тодорхойлолтын хувьд ерөнхийд нь ангилах юм бол өргөн ба явцуу гэсэн хоёр ангид хувааж болох юм. Өргөн ангилалд багтах тодорхойлолтууд нь иргэдийн улс төрийн мэдлэг, үнэлэмж, хандлага, үйл ажиллагааны загвар, улс төрийн байгууллагууд, хууль тогтоомж гэх мэт маш олон зүйлийг хамруулан тоочсон тодорхойлолтууд байдаг. Ийм тодорхойлолтууд нь чухам яг улс төрийн соёл гэдэг үзэгдлийн мөн чанарыг бүдгэрүүлэх учраас судалгаанд ашиглах боломжгүй гэж үзэж байна. Харин явцуу тодорхойлолтууд нь судалгааны хэрэгсэл болох боломжтой. Тэдгээр нь хэдийгээр хоорондоо ялгаатай боловч үндсэн санаагаараа ижил бөгөөд олон янзын тодорхойлолтыг харгалзан ерөнхий байдлаар хэлэх юм бол улс төрийн соёл гэдэг бол иргэдийн улстөр, улс төрийн системд хандах хандлага мөн гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа юм.

Улс төрийн соёл нь ер нь соёл хэмээх ойлголтод багтах учир соёлын нийгмийн үүргийг гүйцэтгэж байдаг нь ойлгомжтой юм. Тэгэхээр улс төрийн соёл нь соёлын нийгмийн үүргийн хүрээнд дараах өвөрмөц үүргүүдийг гүйцэтгэж байдаг хэмээн үзэж болох юм. Үүнд:

- *Танин мэдэхүйн үүрэг.* Тухайн үед нийгэмд үйлчилж байгаа улс төрийн соёл нь нийгмийн гишүүдэд тодорхой мэдрэмж хандлагыг төлөвшүүлэхэд нөлөөлж нийгэмшүүднэ. Өөрөөр хэлбэл, улс төрийн тухай мэдлэг, түүнд оролцох дадлага эзэмшүүддэг.
- *Үнэлгээ буй болгох.* Улс төрийн байгууллага, улстөрчид, улс төрийн үйл явдлын талаар нийгмийн болон нийгмийн бүлгүүдийн санаа бодол төлөвшихөд нөлөөлдөг.
- *Сэтгэл зүйн үүрэг.* Иргэн, улс төрийн намын гишүүн, бусад бүлгийн гишүүний хувьд адилсах, улс төрийн аливаа, чиг шугам, үйл явдлыг дэмжих сэдэл, сэтгэл хөдлөл буй болох буюу буй болсон байдал, эсвэл энэ бүхнийг эсэргүүцэх, өөрөөсөө тусгаарлах, үгүйсгэхэд хүргэдэг сэтгэл хөдлөл буй болгох зэргийг эл үүрэгт хамааруулан үзэж байна.
- *Нийгмийн улс төрийн байдлыг тогтворжуулах үүрэг.* Энэхүү үүргийн хүрээнд улс төрийн соёл нь эерэг утгаараа улс төрийн аль нэг дэглэмийг төлөвшүүлэх, улс төрийн аливаа хямрал гарахгүй юмуу гүнзгийрэхгүй байхад нөлөө үзүүлднэ. Гэвч нөгөө талаас эсрэгээр тогтвор алдагдуулах, байнгын зөрчил тэмцэлтэй байх нэг хүчин зүйл ч болж болно.

Улс төрийн соёлын бүрэлдэхүүн болон нийгмийн үүрэг тухайн нийгэмд, тодруулбал, эл судалгааны хувьд Монгол улсад ямар байгааг судалж дүгнэхэд ашиглах үзүүлэлтүүдийг тодорхойлох нь судалгааны үзэл баримтлалын бас нэг зорилго мөн. Уламжлал ёсоор улс төрийн соёлыг ангийн ухамсар, ангийн

сонирхолтой холбон үздэг байсан билээ. Гэвч ХХ зууны 60- аад онд Европт, ялангуяа Францад өрнөсөн эсэргүүцлийн хөдөлгөөн огт өөр дүр зургийг харуулсан байна. Түүнийг судласан эрдэмтэд тухайлбал, Рональд Инглхарт уламжлалт ангич үзлийн дагуу судалгааны таамаглалыг гаргасан боловч судалгааны үр дүн огт өөр зүйлийг харуулсан байна. Ажилчин анги зүүний намыг, хөрөнгөтнүүд Де Голлийн намыг дэмжинэ хэмээн үзэж байсан боловч ажилчин ангийн дийлэнх нь Де Голлийн намыг дэмжиж сонгуулийн ялалтанд хүргэсэн байна.

Нээлттэй асуултуудын шинжилгээ болон бусад судалгаанаас ахмад ажилчид өндөр цалинтай болохыг хүсэж байгаа нь харагдсан бол залуус илүү их эрх чөлөөтэй, бие даасан байдалтай байх, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж болдог нийгэмд амьдрахыг хүсэж байгаа нь харагджээ. Энэ нь дэлхийн хоёрдугаар дайны дараах эдийн засгийн өсөлт, хүмүүсийн аж амьдралын дээшлэлттэй холбоотойгоор дайны дараах үеийнхэний үнэлэмж өөр болсны үр дүн байжээ.¹ Европын орнуудад болж өнгөрсөн болон одоо өрнөж байгаа үйл явц, түүнээс үүдсэн хүмүүсийн үнэлэмжийн өөрчлөлт манай оронд өөр байх нь мэдээж юм. Гэвч ардчиллын хөгжил болон иргэний улс төрийн соёл хоёрыг ямар нэг байдлаар шалтгаант холбоотой хэмээн үзвэл ерөнхий хандлага байж болохыг үгүйсгэж болохгүй юм.

Нэг. Иймээс улс төрийн соёлын судалгааны нэг үндсэн таамаглал бол улс төрийн соёлд хэрэгцээ, түүний хангалт нөлөөтэй гэдэг юм. Хүмүүсийн амьдралын төвшин хэтэрхий дорой байх үед ардчилал тэдэнд хамаатай биш байна. Тухайн үед хүний аль нэг хэрэгцээ хамгийн чухал байхад бусад дээд шатны хэрэгцээ «нуугдаж буй» мэт байдаг. Үүнийг А.Масловын хүмүүний хэрэгцээний шатлалын онол («Онол сэтгүүл») нотолсон байдаг нь үнэмшилтэй гэж үзэж байна. Амьдралын төвшин дээшлэхийн хэрээр үнэлэмж өөрчлөгдөнө. Тэгэхдээ үүнд боловсролын байдал тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлнэ гэж таамаглаж байна. Өөрөөр хэлбэл амьдралын төвшин нь дунд давхаргад хүрээгүй ч гэсэн эрх чөлөө мэтийн үнэлэмжтэй болсон байх магадлал бий. **Хэрэгцээ, түүний хангамжтай холбогдон хүний үнэлэмж хоорондын хамаарал манай орны хувьд ч үйлчилнэ хэмээн үзэж болох юм.**

Хоёр. Улс төрийн соёлыг судлахдаа ерөнхийдөө ямар байна гэдэг талаар бус түүний шинж чанарууд нь манай оронд нэгэнт буй болсон ардчилсан ёсыг дэмжих болон үл дэмжих талаасаа ямар нөлөөтэй болохыг судлах нь зүйтэй юм. Эдгээр шинжийн ямар байгаагаас ардчилал бүрэн, тал хагас, хуурамч байгаа эсэх нь хамаарах юм. Үүнтэй холбоотойгоор хүмүүсийн улс төрийн соёлын чухам ямар шинж нь ардчилалтай холбоотой вэ гэдэг асуулт гарна. Рональд Инглхарт, Христиан Велцель нар *ардчиллын хөгжилтэй шууд холбоотой шинж бол хүмүүсийн өөрийгөө илэрхийлэх*

¹ Russell J. Dalton, Christian Welzel. The Civic Culture Transformed. Cambridge University Press, 2014, p. XVI

эрмэлзэл юм¹ гэж үзжээ. Хүний улс төрийн соёлын энэхүү шинж нь хүн нийгэмд баригдахгүй, илүү их чөлөөтэй байх, бие даах, хүсэл эрмэлзэлдээ нийцүүлэн сонголт хийх явдлаар илэрхийлэгддэг байна. **Ерөнхий хандлага болохын нь хувьд үүнийг монголчуудын хувьд ч байж болох үзүүлэлт хэмээн үзэж болох юм.**

Дээрх судлаачид хүмүүсийн улс төрийн соёлын энэхүү шинж давамгайлваас нийгмийн ардчилал тогтох юмуу улам бэхжинэ гэж үзсэн байна. Гэвч тэдний үзэлд эргэлзээ төрүүлэх зарим зүйл байгаа нь тэд ингэснээр юм бүхний төвд хүн байж, нийгэм улам бүр хүмүүнлэг болно гэж үзсэн нь юм. Хүний өөрийгөө илэрхийлэх эрмэлзэл нь ардчилалд нөлөөтэй байж болох боловч, нийгмийн хүмүүнлэг шинж бүрэлдэхтэй ийм шууд хамаарал байна гэдэг нь эргэлзээтэй юм. Европ, Америкийн олон оронд явуулсан улс төрийн соёлын судалгааны дүнгээс харахад иргэд бие даасан, илүү чөлөөтэй байдлыг эрмэлзэхийн зэрэгцээ улс төрийн амьдралаас хөндийрэх байдалтай байгаа юм. Хамгийн гол нь төрийн үйл ажиллагаанд сэтгэл дундуур, төрд итгэх нь сул болсон байгаа юм. Үүнийг судлаачид нэг талаас ардчиллын эрэлт их байхад нөгөө талаас нийлүүлэлт бага байна гэх мэтээр тайлбарлаж байна. Энэ нь институтцийн алдаа хэмээн үзэж байна. Ийм байдлыг ардчилсан тогтолцооны гажиг хэмээсэн дүгнэлт одоогоор байхгүй боловч ардчилсан тогтолцоо хямралд орж байгаа эсэх талаар яриа хэлэлцүүлэг өрнөдөг болсон байна.

Гурав. Онцлон тэмдэглэвэл зохих зүйл бол төрийн үйл ажиллагаа, түүний үр дүн, төр энгийн иргэдийн төлөө ажилладаг эсэхэд эргэлзсэн байдал дэлхий нийтэд түгээмэл байгаа юм. Өөрөөр хэлбэл, өмнө нь ардчилсан гэгдэж байсан болон ардчиллын шинэ давалгаа гэж нэрлэгддэг өөрчлөлтийн үед ардчилсан тогтолцоотой болсон орнуудын аль алинд нь төстэй байдал ажиглагдаж байна. **Судалгааны ажлын дараагийн таамаглал бол манай оронд энэхүү хандлага бас байгаа гэдэг юм.**

Дөрөв. Улс төрийн соёл нь хэдийгээр орон бүрт, үндэстэн бүрд өөр өөрийн онцлогтой байдаг боловч бодит, нийтлэг үзэгдлийг илэрхийлдэг шинжлэх ухааны ойлголт болохын хувьд нийтлэг гэж болмоор хэмжигдэхүүнүүдтэй байдаг. Тэдгээрийг ашиглах нь судалгааг тодорхой, чиглэлтэй болгох бөгөөд аль ч нийгмийн гишүүдийн улс төрийн соёлын ерөнхий дүр зураг, нийгмийн бүлгүүдийн ялгарал гэх мэтийг тодорхойлж болно. Судлаачдын явуулсан судалгааг үзэхэд улс төрийн соёлын дараах шинжүүдэд анхаарал хандуулсан байдаг. Үүнд:

- уламжлалт болон модерн шинж (иррациональ болон рациональ хандлага)
- шашны болон шашингүйн үзэл
- хамт олонч болон хувьч шинж
- Үндэсэрхэг үзэл ба космополитанизм

¹ Modernization, Cultural Change, and Democracy: The Human Development Sequence. Cambridge University Press, NY, 2005

- улс төрийн байр суурь (улс төрийн аль нэг чиглэлийг байнга дагах, намд хамаарагдах г.м.)

Тав. Улс төрийн соёлын судалгаанд **улс төрийн оролцооны асуудал чухал байр эзэлнэ.** Габриел Алмонд, Сидней Верба нар дэлхийн хоёрдугаар дайны дараа дэлхий дахины улс төрийн амьдралд хувьсгал гарсан нь иргэдийн оролцооны дэлбэрэлт болсон явдал хэмээн¹ үзсэн байдаг. Оролцоо нь нэг талаас иргэний соёлын, нөгөө талаас системийн шинж чанарыг илэрхийлдэг учраас улс төрийн соёлын чухал үзүүлэлт байдаг. Иргэний оролцоо идэвхтэй болон идэвхгүй байж болох бол системийн зүгээс оролцооны бололцоог хангадаг болон хангадаггүй байж болно. Үүнтэй холбоотойгоор:

- оролцооны хэмжээ (оролцдог болон оролцдоггүй, давтамж)
- оролцооны шинж (нийцтэй хэлбэрийн болон нийцгүй хэлбэрийн оролцоо)
- оролцооны сэдэл (өөрөө сонирхлоо хамгаалж зориуд оролцдог, бусдыг дагалддаг, хөлсөөр оролцдог г.м.)

Зургаа. Анхаарал татах өөр нэг асуудал бол социалист нийгэм иргэдийн улс төрийн соёлд хэрхэн нөлөөлснийг тодорхойлох явдал юм. Энэ үед хүмүүст буй болсон шинж нь дээр дурдсан шинжүүдэд багтах боловч хүнийг бүхэлд нь авч үзвэл монгол хүн ямар байгаад ардчиллын үед ямар болсон бэ гэдэг асуудал сонирхол татаж байгаа юм. Үүнийг социалист байсан зарим орны судлаачид өөрийн орны жишээн дээр судлаад хүн «Homo sovieticus» байснаа «Homo democraticus» болж хувирсан тухай бичсэн тохиолдол байна. **Монгол хүн монгол чигээрээ үлдэж зарим шинж нь өөрчлөгдсөн боловч ийнхүү хэв шинжийн хувьд бүрэн өөрчлөгдөөгүй хэмээх таамаглалыг дэвшүүлж болох юм.**

Долоо. Улс төрийн соёлын бас нэг чухал үзүүлэлт бол иргэний иргэнлиг байдал юм. Энэ нь манай орны хувьд иргэний эрх үүргийг аль алиныг нь харгалзсан үзүүлэлт бөгөөд магадгүй онцлог үзүүлэлт байж болох юм. Сүүлийн жилүүдэд манай оронд социаль капитал тодорхой хэмжээгээр буурсан нь хямралыг хамтын хүчээр шийдвэрлэх чадвар дутмаг буйг харуулж байна.

Найм. Улс төрийн соёлын эерэг болон сөрөг өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээ хийх нь зайлшгүй юм. Үүнд:

- ардчиллын үед хувь хүн улс төрийн эрх чөлөөтэй болсон явдал
- мэдээлэл авах боломж нэмэгдсэн явдал
- мэдээллийн хэрэгслийн агуулга
- өрнөдийн олон нийтийн соёлын түрэлт
- төр засгийн иргэдээ хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх талаар явуулж буй үйл ажиллагаа
- улс төрийн намууд, ТББ-ын үйл ажиллагаа
- хүмүүсийн аж амьдралын төвшин
- сургууль, хүүхдийн байгууллагын үйл ажиллагаа
- гэр бүлийн нөлөө

¹ Gabriel A. Almond, Sidney Verba. The Civic Culture: Political Attitudes and Democracy in Five Nations. 1989, Sage Publications, p.2

Сэдвийн судлагдсан байдал

Улс төрийн соёл гэдэг нэр томъёог анх XVIII зуунд Германы философич Иоганн Гердер бүтээлүүддээ дурдсан байдаг. Улс төр судлаач Э.Вятра, А.Боднар нарын үзэж байгаагаар улс төрийн соёл бол төр засаг, иргэдийн хоорондын харилцааны талаархи байр суурь, үнэт зүйл, ёс зүйн дүрмийн хослол юм. Боднарын үзэж буйгаар улс төрийн соёл бол амьдралын янз бүрийн асуудлын талаар ил болон далд санаагаар тогтсон түүхэн цогц юм. Үүнд:

- ❖ улс төрийн хэм хэмжээ;
- ❖ улс төрийн байгууллагууд;
- ❖ улс төрийн хэв маяг;
- ❖ хувь хүн ба нийгмийн бүлгүүдийн улс төрийн үйл ажиллагааны арга.

Чингэвэл, Фрэнсис Фукуяма “соёл” хэмээхүй гүн утга бүхий ойлголт бөгөөд өөртөө гэр бүлийн бүтэц, шашин шүтлэг, үнэт зүйлс, ухамсар, иргэншил, түүхэн уламжлал гэх үзэгдлүүдийг багтаадаг гэжээ. Соёлыг уламжлалаар дамжсан оюунлаг ёс зүйн зуршил гэж тайлбарлаж болно. Хэдийгээр үзэл суртал, институтууд, иргэний нийгмийн түвшинд болж буй үйл явдалд соёл нь шууд нөлөөлдөг боловч, хамгийн удаан өөрчлөгдөх хандлагатай байдаг хэмээн үзсэн нь бий. Улс орон бүр өөрсдийн түүхэн уламжлалт соёлын тогтоцтой. Энэ ч утгаараа соёл гэх ухагдахуун нь өөрөө хүн, байгаль, нийгмээс үүдсэн нэгдмэл ойлголт бөлгөө. Монгол хүний уламжлалт сэтгэхүй, байгаль хүн хоёрын харилцаа холбоо, түүнийгээ дээдэлж ойлгох мэдрэхүйн онцлог чанарынхаа хувьд тогтсон соёл гэх ойлголт бусад орны судлаачдын анхаарлыг татсаар ирсэн байдаг. Үүний тод жишээ бол, профессор Ё.Довчин, профессор Э.Тамир зэрэг эрдэмтэд улс төрийн соёлын төлөвшилөөр эрдмийн зэрэг хамгаалсан бол, Д.Содномгомбо, Ч.Найдансүрэн нар «Улс төрийн соёл, түүний Монгол дахь төлөвшилийн асуудал» сэдвээр хамтын бүтээлийг, Г.Алмонд, Ж.Пауэлл нарын туурвисан «Харьцуулсан улс төр (онолын хүрээ)» бүтээлийг Ё.Довчин, Ш.Содном нар англи хэлнээс орчуулан хэвлэсэн байдаг. Гэвч улс төрийн соёлын асуудлыг онол, практикийн түвшинд иж бүрэн нарийвчилсан суурь судалгаа хийж нухацтай судалсан явдал дутмаг байсаар ирсэн. Энэ удаад ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд, эрдэмтэн судлаачид улс суурьтайгаар тоон болон чанарын судалгааны аргаар нарийвчлан судалсаны дээр агуулгын хийгээд харьцуулсан улс төрийн судалгааны аргаар цогцоор судалсан нь нэг талаас шинжлэх ухааны болон нийгмийн чухал ач холбогдолтой ажил болсон. Энэ хүрээнд судлаачид маань судалгаа, шинжилгээний үр дүнгээр хамтын бүтээл туурвисан нь эл хөндөн буй судалгааны чиглэлийг нэг шатаар ахиулсан хэмээн үзэж болно.

Судалгааны онол арга зүйн үндэс

“Улс төрийн соёл” хэмээх ойлголтыг XVIII зуунд германы гүн ухаантан И.Гердер (1744-1803) анхлан хэрэглэсэн гэж үздэг. “Хүн төрөлхтөний философийн үзэл санааны тухайд” хэмэх бүтээлдээ тэрээр энэхүү хос үгийг хэрэглэснээс гадна улс төрийн соёл болон түүнийг тээн явагчдын асуудлыг хөндөж тавьсан байдаг. Тэрээр эл бүтээлдээ хүн төрөлхтөний соёлын түүх, шашин, яруу найраг, урлаг, шинжлэх ухааныг авч үзэн улс орон бүрийн үндэсний өвөрмөц соёл үнэ цэнэтэй болох тухай үзэл санааг дэвшүүлж, улс төрийн байгууллага чухал боловч соёлын хүчин зүйл анхдагч болдог үндсэн дүгнэлтэд хүрсэн ажээ.

Улмаар, улс төрийн соёлын талаарх онол парадигм үүсэн бий болоход Н. Макиавелли, Ш.Монтескье, Ж.Ж.Руссо, А.Токвиль, Г.Моска, В.Парето, Р.Михельс, К.Маркс, М.Вебер нарын эрдэмтэн судлаачдыг үнэтэй хувь оруулснаар XIX-XX зуун гэхэд тус ойлголтыг шинжлэх ухааны түвшинд өргөнөөр хэрэглэх болсон. Жишээлбэл, улс төрийн субъектүүд болох бие хүн, бүлэг, нийтлэгүүдийн улс төрийн талаарх төсөөлөл, үнэт зүйлс болон бодит улс төр харилцан хамааралтай болохыг сэргэн мандалтын үеийн төлөөгчид болох *Н.Макиавелли, М.Монтень нар ч мөн адил* үзэж байжээ.

Хожим нь XX зуун бол бол улс төрийн соёлын талаарх онол парадигмын төлөвшил болон цэцэглэлтийн эрин зуун гэж хэлж болно. Энэ зуун дахь улс төрийн соёлын талаарх онол парадигмын хөгжлийн үндсэн гурван үед хувааж авч үздэг. Нэгдэх үе нь 1920 оноос 1940-өөд он хүртэл үргэлжилсэн бол улс төрийн соёлын талаарх эрэл хайгуулын хоёр дахь давалгаа 1950-1960 оныг хамарч, 1980 оны сүүлчээс 90 оныг дуустал гурав дахь үе үргэлжилсэн байдаг.

Улс төрийн соёлын онол парадигмын хөгжлийн хоёр дахь давалгаа өрнөхөд 1950-1960 онуудад Ази, Африкийн орнуудад өрнөсөн колонийн эрхшээлээс гарах үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ихээхэн түлхэц өгсөн гэж үздэг. XX зууны 50-аад оноос улс төр судлалын хүрээнд улс төрийн соёлын үзэл баримтлалыг боловсруулах ажил өрнөсөн түүхтэй. Өрнөдийн зарим томоохон судлаачид ардчиллын эцсийн хамгийн бодит хэмжүүр нь улс төрийн соёлын төлөвшил хэмээн үздэг. Орчин үеийн улс төр шинжлэлийн томоохон онолчид Г.Алмонд, С.Верба, Л.Пай нар улс төрийг соёлын хэмжүүрээр хэмжиж, улс төрийн соёлын тодорхой загвар, үнэт зүйлс, итгэл үнэмшлийн бүхэл тогтолцоот үзэл баримтлалыг санал болгосон байдаг. Үүнийгээ тэд: *“нийгмийн улс төрийн соёлын тухай бид ярихдаа түүний гишүүдийн мэдлэг мэдрэмж, үнэлэмж болж хувирсан улс төрийн системийг авч үзэж байгаа хэрэг”*¹ хэмээн тодотгосон байдаг. Түүнчлэн судлаач Л.Пай “улс төрийн соёл бол улс төрийн системийн агуулга хэлбэрийг тодорхойлж байдаг тулгуур үнэт зүйлс, мэдрэмж, мэдлэгийн нийлбэр цогц мөн. Ингэхлээр улс төрийн соёлыг бүрдүүлэгч элементүүд нь хувь иргэдийн төр засагт чиглэсэн итгэл бишрэл, санаа бодол, сэтгэл хөдлөл байх болно”² хэмээсэн байдаг. Энэ

¹ Almond. G and Verba. S. The Civic Culture Revisited, Boston: Little Brown, 1980

² Сморгунов Л.В. Третья волна демократизации как проблема сравнительной политологии (Политические процессы в России в сравнительном измерении. СПб., 1997)

агуулгаараа тэд улс төрийн соёлыг “улс төрийн объектуудад хандах улс төрийн субъектын итгэл үнэмшил, чиг баримжааны цогц” хэмээн тодорхойлсон байна. Соёлын элементийг агуулаагүй улс төр, нийгмийн ямар нэг үзэгдэл, үйл явц гэж байхгүй.

Монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлт хувьслын сонирхолтой үедээ ороод байна. Үүнтэй уялдан улс төрийн соёлын хүрээнд шийдвэрлэж хариу өгвөл зохих олон асуудал хуримтлагдаж байна. Иймд иргэдийн улс төрийн соёлын өөрчлөлт, шинэчлэлт, төлөвшлийн хүрээний асуудлыг нарийвчлан судлаж хариу өгөх нь нэн чухал юм. Чингэхлээр, “*төлөвшил*” хэмээх ойлголт нь улс төрийн соёлын хувьд өргөн дэлгэр хэрэглэгддэг суурь томъёо юм. “*Улс төрийн соёлын төлөвшил*” хэмээх ойлголт нь харьцуулсан улс төр судлалын шинжлэх ухаанд улс төрийн соёлын хувьсал, өөрчлөлтийн үйл явцын хүрсэн түвшин, түүний хүрээнд илрэх, тэдгээрийн үйлчлэн орших динамик шинжийн илэрхийлэл гэдэг утгаар тайлбарладаг. Улс төрийн соёлын төлөвшлийн үйл явц нь бүхий л цаг үед үргэлжлэн хэрэгжиж байдаг үзэгдэл юм. Улс төрийн соёл нь нийгмийн оюун санаанд бүрэлдсэн итгэл үнэмшил, ёс заншил, уламжлалт сэтгэлгээтэй холбоотой байдаг учраас түүний өөрчлөлт удаан явагддаг. Нийгмийн давхраа бүрийн улс төрд хандах хандлага харилцан адилгүй байна. Ардчилсан нийгмийн тогтвортой байх чухал нөхцлийн нэг нь улс төрийн соёлын идэвхтэй оролцоо давамгайлсан хэв маягийг бүрдүүлэх явдал бөгөөд энэхүү суурь судалгааны төслийн гол цөм оршино.

Судалгааны арга зүй, аргачлал

«Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» (2017-2019) суурь судалгааны төслийн хүрээнд «*Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага*» сэдэвт олон нийтийн санал асуулгыг Улаанбаатар хотын 6 дүүрэг болон Дундговь, Дорнод, Орхон, Сэлэнгэ, Ховд аймгуудад зохион байгуулсан. Чингэхдээ бид монголын нийгмийн улс төрийн соёлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг тодруулж, улмаар улс төрийн соёлын талаарх орчин үеийн онолд тулгуурлан дүгнэлт гаргах, таамаглалаа шалгах, онолын шинжтэй шинэ санаа дэвшүүлэхийг зорьсон болно. Мөн дараах асуудлын хүрээнд өнөөгийн Монголын улс төрийн соёл хийгээд түүний төлөв байдал, чиг хандлага, төсөөлөл, иргэдийн санаа бодлыг тодруулснаараа энэхүү тоон болон чанарын судалгааны гол зорилго оршив.

Санал асуулгын үндсэн асуултууд

1. Улс төрийн мэдлэг
 - Манай улсад хэн хууль гаргадаг вэ?
 - Иргэдийн төлөөлөгчдийн хурал ямар байгууллага вэ?
 - Иргэний улс төрийн үндсэн эрх чөлөөг нэрлэнэ үү
 - Та хувь хүний орлогын албан татварыг хэдэн хувиар төлдөг вэ?
 - Та улс төрийн мэдлэгээ ямар эх үүсвэрээс авдаг вэ?
2. Төр засагт хандах хандлага
 - Төр засгийн бодлогот таны адил хүмүүс нөлөө үзүүлж чадах уу?
 - Засгийн газар, УИХ аливаа шийдвэр гаргахдаа жирийн хүмүүсийн тухай боддог гэж та боддог уу?
 - Манай улсад төрийн томчууд зөвхөн өөрийгөө л боддог гэсэн яриа байдаг. Та зөвшөөрч байна уу?
 - Та зөвхөн энэ удаагийн ч биш, ер нь Засгийн газар танд тусгай зүйл хийнэ гэдэгт итгэдэг үү?

- Та манай төрийн тогтолцоо болон Хятад улсын төрийн тогтолцоог харьцуулбал аль нь дээр гэж үздэг вэ?
3. Улс төрийн үнэлэмж
- Та чөлөөтэй байж амьдралаа өөрөө авч явах болон төр туслаж дэмжиж байвал ажил, амьдралд оролцож байх хоёрын алийг нь илүүд үзэх вэ?
 - Та хэвлэл мэдээллийг төрөөс сайн зохицуулж байх ёстой гэж үзэж байна уу, эсвэл хэвлэл мэдээлэл чөлөөтэй ажиллаж байх ёстой гэж үзэж байна уу?
 - Та өөрийнхөө эрхийг эдлэхдээ бусдын эрхээ эдлэх боломжийн тухай боддог уу?
4. Уламжлалт болон модерн шинж
- Ямар нэг асуудлаар Та хамт олноосоо юмуу нутгийнханаасаа өөр саналтай байх тохиолдолд Та өөрийнхөө саналаар шийдвэр гаргадаг уу, эсвэл бусдыгаа дагадаг уу?
 - Элдэв уламжлал, заншлыг заавал дагах ёстой гэж Та үздэг үү?
 - Гэр бүлд эцэг шийдвэрлэх үүрэгтэй гэдэгтэй Та санал нэгдэх үү?
 - Уул, усанд эзэн байдаг гэдэгт та итгэдэг үү?
 - Та өөрт чинь ашигтай байвал муу гэж үзсэн хүнтэйгээ хамтран ажиллах уу?
 - Ардчилал болон дэг журам хоёрын аль нэгийг сонго гэвэл аль нь танд чухал вэ?
 - Та телевиз радио, олон нийтийн сүлжээ зэргийн талаар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ?
5. Шашин шүтлэг
- та ямар нэг шашин шүтдэг үү?
 - Та лам багштай юу?
 - Та хувь заяагаа даатгах, хүсэлт тавих зэргээр аль нэг шашны бурханд ханддаг уу
 - Та сонгуульд өрсөлдөж байгаа хүний аль нэгийг сонгохдоо өөрөөс чинь өөр шашин шүтдэг хүнийг сонгох уу?
 - Та шашин шүтлэгийнхээ төлөө тэмцэх ёстой гэж боддог уу?
 - Таны охин юмуу хүү өөр шашинтай хүнтэй гэрлэх гэвэл та яах вэ?
6. Хамт олонч болон хувьч үзэл
- танд хамт олны эрх ашгийн төлөө өөрийнхөөсөө татгалзсан удаа бий юу?
 - Ер нь хамт олны эрх ашиг хувийн эрх ашиг хоёрын алийг нь та ихэвчлэн илүүд үздэг вэ?
 - Хамт олноосоо тасарсан, хувиа бодсон хүнийг хараад та юу гэж боддог вэ?
 - Онцгой байдлын үед хүн амиа бодох нь зөв үү
 - Та чөлөөт цагийнхаа хэдэн хувийг хүмүүстэй уулзах, тоглох, аялж зугаалах, дуулж хөгжих байдлаар өнгөрөөдөг вэ?
7. Үндсэрхэг үзэл
- Та үндсэрхэг хүн үү?
 - Таны охин гадаадын хүнтэй гэр бүл болох гэвэл та зөвшөөрөх үү?
 - Үндэсний үзэлтэй байх гэж чухам юуг хэлэх вэ? (нээлттэй байж болно)
 - Та уртын дуунд хэр дуртай вэ? Хэр байнга сонсдог вэ?
 - Та малд хайртай юу?
 - Зарим хүн сайхан л амьдарч байвал заавал Монголдоо амьдрах албагүй гэж үздэг. Та үүнтэй хэр санал нийлэх вэ?
8. Улс төрийн байр суурь хандлага
- Та аль нэг намын гишүүн мөн үү?
 - Та аль нэг намыг сонгуульд ялуулахын тулд түүний өмнөөс ухуулга сурталчилгаа хийж байсан уу?
 - Танд аль нэг намын байр суурийг хамгаалж бусадтай маргах явдал гарч байсан уу?
 - Та үр хүүхдээ өөрийнхөө дэмждэг намыг дэмждэг болоосой гэж хүсдэг үү?
 - Та аль нэг намын нэрээр ямар нэг сонгуульд өрсөлдөж байсан уу?
 - Хүмүүс сонголт хийхдээ намуудын мөрийн хөтөлбөрийг уншиж ойлгосоны үндсэн дээр сонголт хийдэг үү?
9. Улс төрийн оролцоо
- Та УИХ-ын сонгуульд байнга оролцож саналаа өгдөг үү
 - Та орон нутгийн сонгуульд байнга оролцож саналаа өгдөг үү
 - Та аль нэг шатны сонгуульд нэрээ дэвшүүлж байсан уу
 - Та жагсаал, цуглаан, суултад оролцдог уу
 - Та өлсгөлөн зарлах мэтийн үйл ажиллагаанд оролцож байсан уу
 - Та УИХ-ын гишүүн, сайд, дарга нарт улс, орон нутгийн амьдралын асуудлаар захиа бичиж байсан уу
 - Та албаны хүмүүстэй хийдэг уулзалтуудад оролцдог уу
 - Та хурал цуглаанд оролцохдоо үг хэлдэг үү

- Та өлсгөлөн зарлах, өөрийгөө шатах мэтийн аргыг юу гэж үздэг вэ
- Том албаны хүмүүст хандан асуулт, хүсэлт тавьснаар үр дүн гарна гэдэгт та итгэдэг үү

10. Иргэнлиг байдал

- Та Монгол улсын иргэн гэдгээрээ бахархдаг уу
- Та иргэний хувьд улсынхаа хуулинд захирагдах ёстой гэж үздэг үү
- Та гадаадад явахдаа эх орныхоо нэрийг бодох ёстой гэж боддог уу
- Та улсынхаа бусад иргэдтэй холбоотой байж , тэднийг тусалж дэмжих ёстой гэж боддог уу
- Та хийж байгаа ажлараа эх орондоо хувь нэмэр оруулах ёстой гэж боддог уу
- Та иргэний хувьд төрийн янз бүрийн шатны байгууллагаас гаргаж байгаа шийдвэрт өөрөө нөлөөлөх ёстой гэж боддог уу
- Та иргэний хувьд төрийн аль ч байгууллагаас гаргаж байгаа шийдвэрийг биелүүлэх ёстой гэж боддог уу
- Манайд иргэнийхээ эрхийг эдлэх, үүргийг биелүүлэх боломж хэр байдаг гэж үздэг вэ
- Та эх орныхоо түүх, соёлыг хэр сайн мэдэх вэ

11. Лидер

- Та хэнийг хамгийн том лидер гэж бодож байна вэ (нээлттэй асуулт)
- Яагаад

12. Манай оронд байсан өмнөх нийгэм буюу социализмын талаар ямар бодолтой байдаг вэ?

Улс төрийн соёлын дээр дурдсан шинжүүдийг тодорхойлж Монгол улсын иргэдийн улс төрийн соёлын талаар дүгнэлт хийхийн тулд эдгээр асуултад хариулт авах нь зүйтэй гэж үзэж байна. Эдгээрийг социологийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар анхдагч мэдээллийн боловсруулалт хийж, улмаар боловсруулсан мэдээлэлд төслийн багийн гишүүд шинжилгээ хийж судалгааны тайланг боловсруулсан. Эдгээрээс гадна хүн ам зүйн мэдээлэл, зарим зүйлийн шалтгаан нөхцөл зэргийг тодруулах асуултыг оруулна. Түүнчлэн асуултууд аль болохоор олон шатлалтай хариулттай байхаар зохиомжилсон билээ.

Гурав. Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ажил, явцын үр дүн, үр дүнгээс гарсан дэвшилтэт талууд

Судалгааны багийн гишүүд, түүний удирдагчийн зүгээс “Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” суурь судалгааны төслийн ажлыг хэрэгжүүлэх календарьчилсан төлөвлөгөөг нарийвчлан шинэчлэн боловсруулж баталсан. Чингэхдээ, салбарын нийт эрдэм шинжилгээний ажилтнуудын эрдэм шинжилгээний жилийн ажлын төлөвлөгөөнд тусгайлан заасан даалгавраар гүйцэтгэх ажлыг үүрэгжүүлсэн нь эл төслийг амжилттай хэрэгжихэд чухал ач холбогдолтой болсон.

Төслийн удирдагчийн хувьд ШУТС-д тухай бүр суурь судалгааны төслийн явцын тайланг хүлээлгэн өгч, үр дүнг тайлагнаж ирсэн.

Мөнхүү суурь судалгааны төлсийн зорилтын хүрээнд, багийн гишүүд дараах бодит нөхцөл байдлыг таван үндсэн хэсэгт ангилан шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлон судалсан нь эл судалгааны дэвшилтэт тал болно. Үүнийг тодруулбал,

Хэсэг I

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр нийгэм, эдийн засгийн байдал ч хувьсан өөрчлөгдөж байдаг учраас бид тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан хэрэглэвэл өнөөгийн өөрчлөгдөж буй нийгэм дэх улс төрийн соёлын үзэгдлийн учир шалтгааныг илүү тод томруунаар харуулснаараа онцлогтой. Чингэхдээ манай орны улс төрийн бодит нөхцөл байдлыг үндэслэлтэй тодорхойлох, улмаар судлаач респонденттой тухайн асуудлаар холбоо харилцаанд орохдоо өөрийн нөөлөөллийг оруулахгүй байхыг гол зорилго болгон Монголын нийгмийн улс төрийн соёлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг тодруулж, улмаар улс төрийн соёлын талаарх орчин үеийн онолд тулгуурлан дүгнэлт гаргах, таамаглалаа шалгах, онолын шинжтэй шинэлэг санааг дэвшүүлсэн.

Хэсэг II

Улс төрийн соёлын талаарх ойлголт, төсөөллийг тоон болон чанарын судалгааны арга зүйгээр тодруулан гаргахдаа чанарын хувьд фокус бүлгийн болон гүнзгийрүүлсэн ганцаарчилсан ярилцлагын хэлбэрээр ИНБ-ууд, хараат бус өндөр төвшний экспертүүдийн төлөөллийг хамруулан судалгааг гүйцэтгэсэн. Эндээс улс төрийн амьдралд ямар байр сууринаас оролцож буй талаар тодруулан асуухад тэдний дийлэнх нь улс төрд идэвхтэй байр сууринаас оролцохыг хичээдэг боловч залуучуудын хувьд эл асуудал төдийлэн хангалттай бус төвшинд оролцдогын зэрэгцээ өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлэхийг зорьдог ч энэ нь амжилтыг эс олдог талаар сонирхолтой дүр зургийг энд агуулсан. Бид, чанарын судалгаандаа дараах асуудлын хүрээнд буюу өнөөгийн Монголын улс төрийн соёл хийгээд түүний төлөв байдал, чиг хандлага, төсөөллийг иргэдийн болон тодорхой зорилтод бүлгүүдийн санаа бодлыг давхар тодруулах оролдлого хийснээрээ эл суурь судалгаа онцлогтой болно.

Хэсэг III

Улс төрийн соёлын төлөншлийн үйл явц нь бүхий л цаг үед үргэлжлэн хэрэгжиж байдаг үзэгдэл юм. Улс төрийн соёл нь нийгмийн оюун санаанд бүрэлдсэн итгэл үнэмшил, ёс заншил, уламжлалт сэтгэлгээтэй холбоотой байдаг учраас түүний өөрчлөлт удаан явагддаг. Энэ утгаараа, иргэдийн ухамсарт ардчиллын үзэл санааны үнэт зүйлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, анархизм руу чиглэсэн үйлдлүүдийг хууль эрх зүйн зохистой бодлогоор хазаарлан барих явдал нийгмийн сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх ач холбогдлыг тодруулсан.

Хэсэг IV

Улс төрийн соёл нь хэдийгээр орон бүрт, үндэстэн бүрд өөр өөрийн онцлогтой байдаг боловч бодит, нийтлэг үзэгдлийг илэрхийлдэг шинжлэх ухааны ойлголт болохын хувьд нийтлэг гэж болмоор хэмжигдэхүүнүүдтэй байдаг. Тэдгээрийг ашиглах нь судалгааг тодорхой, чиглэлтэй болгох бөгөөд аль ч нийгмийн гишүүдийн улс төрийн соёлын ерөнхий дүр зураг, нийгмийн бүлгүүдийн ялгарал гэх мэтийг тодорхойлох шинжилгээг хийсэн.

Хэсэг V


Ардчилал, эрх чөлөөний талаарх хэт ерөнхий, гэнэн төсөөлөл, улс төрийн соёлын доогуур төвшингөөс хамаарч эрх зүйт төр, ардчиллын хөгжилд бэрхшээл, хүндрэл гарч, улмаар гажуудал, завхрал алхам алхамаар газар авах боллоо. Энэ нь өнөөгийн Монгол Улсад иргэний нийгмийн хяналтын үүргийг бэхжүүлж, урамшуулах цаг үеийн шаардлага бий болсныг харуулахын зэрэгцээ ИНБ-уудын ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх боломжийг дурдсан дүгнэлт, зөвлөмжийг агуулсан «Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе» хамтын бүтээлийг туурвисан болно.

Дээрхийг багцлан үзэхэд, Монголын хөгжилд үзүүлж буй улс төр, засаглалын нөлөөллийн хүрээнд улс төрийн соёлын нөлөөллийн байдал төлөв, үүрэг ямар байна, хөгжилд үзүүлэх соёлын зохистой хүчин зүйл, нөлөөлөл түүний онол-арга зүй чиг баримжааг боловсруулан томъёолж, практик нөлөөллийн үр ашиг, түүний зохистой загвар хувилбарыг боловсруулан санал болгоход оршсон бөлгөө. Товчоор хэлбэл хөгжил, улс төрийн соёлын харилцан хамаарал, тэдгээрийн эргэж нөлөөлөх зүй тогтлыг судлан тодорхойлоход суурь судалгааны төслийн гол зорилго оршиж, ийнхүү үр дүнтэй хэрэгжихэд чухал нөлөө үзүүлсэн болно. Түүнчлэн суурь судалгааны төслийн хүрээнд хийх ажлын чиглэл, хариуцаж хэрэгжүүлэх сэдэв, асуудлын тоймыг хамтран хэлэлцэж, судалгааны онол-арга зүйн ерөнхий чиг баримжааг гаргах, холбогдох мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг бүрэн гүйцэтгэсэн нь судалгааны багийн оролцогчдын хичээл зүтгэл, идэвх санаачлагын үр дүнд бий болсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ажлууд


Суурь судалгааны төслийн хүрээнд хийх ажлын чиглэл, хариуцаж хэрэгжүүлэх сэдэв, асуудлын тоймыг хамтран хэлэлцэж, судалгааны онол-арга зүйн ерөнхий чиг баримжааг гаргах, холбогдох мэдээллийн санг бүрдүүлсэн. Тухайлбал, (i) тус суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн олон нийтийн санаа бодлын судалгаанд нийт 1039 иргэд хамрагдсан бөгөөд тэдгээр иргэдийн судалгааны анкет хэрэглэгдэхүүнд боловсруулалт хийж, судалгааны тайланг боловсруулсаны дээр суурь-дата мэдээллийн баазыг бүрдүүлсэн; (ii) өндөр төвшний 40 гаруй шинжээчдийн дунд экспертийн судалгааг зохион байгуулж мөн тооны мэдээллийн санг цуглуулж, мэдээлэлд шинжилгээ хийж тусгайлсан тайланг боловсруулсан; (iii) чанарын судалгааг таван үндсэн референт бүлгийн дунд зохион байгуулж 40 орчим респондентуудтай бүлгийн болон гүнзгийрүүлсэн ганцаарчилсан ярилцлага хийж, түүндээ шинжилгээ хийж тайлан боловсруулсан; (iv) судалгааны тухайлсан үзэл баримтлалыг боловсруулж түүний хүрээнд хамтын бүтээлийг боловсруулах, тоон болон чанарын судалгааг зохион байгуулсан болно. Бид, эл суурь судалгааны төслийн хэрэгжсэн (2017-2019) хугацаанд гүйцэтгэх үр дүнгийн даалгаварын хүрээнд 144 бүтээгдэхүүнийг нийлүүлсэн. Тэдгээрийг дараах байдлаар тайлагнаж байна.

Зураг 1. Үр дүнгийн даалгаварын хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн
(ангилал бүрээр)



Суурь судалгааны төслийн хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүнийг он тус бүрээр ангилан үзвэл, суурь судалгаа хэрэгжиж эхэлсэн эхний жилд төслийн багийн гишүүд 41 бүтээгдэхүүн нийлүүлснээс эрдэм шинжилгээний өгүүлэл 12, илтгэл 17 хэлэлцүүлснээс 3 нь гадаадад хэвлэгдсэн байна. 2018 онд төслийн багийн гишүүд нийт 36 бүтээгдэхүүн гүйцэтгэснээс эрдэм шинжилгээний өгүүлэл 17 хэвлүүлснээс 6 өгүүллийг гадаадад хэвлүүлсэн бол эрдэм шинжилгээний 14 илтгэлээс 3-ыг гадаадад хэлэлцүүлжээ.



Зураг 2. Үр дүнгийн даалгаврын хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн (он, гүйцэтгэлээр)



Нөгөөтгээгүүр, суурь судалгааны хэрэгжилтийн сүүлийн жилд төслийн багийн гишүүд өмнөх 2017 онд нийлүүлсэн бүтээгдэхүүнээс 1.5 дахин, 2018 оныхоос 1.7 дахин илүү бүтээгдэхүүн нийлүүлсэн нь төслийн багийн удирдагчийн зүгээс багийн нийт гишүүдийн ажлын ачаалал, үр дүн, хариуцлагыг өндөржүүлсэнтэй шууд холбоотой. Түүнчлэн тоон үзүүлэлтээс чанарын үзүүлэлт рүү түлхүү анхаарч ажилласан нь эл суурь судалгааны төслийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал алхам болсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Төслийн багийн гишүүдийн нийлүүлсэн бүтээгдэхүүний жагсаалтыг (Хавсралт 1)-, техникийн ажлын даалгаварын биелэлтийг (Хавсралт 2)-оос тус дэлгэрүүлэн үзэж болно. Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг эрдэм шинжилгээний ажилтан тус бүрээр ангилан үзвэл:

Зураг 2. Үр дүнгийн даалгаврын хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн (ЭША-нуудаар)



Дөрөв. Суурь судалгааны төслийн үр дүнд суурилсан дүгнэлт

Ардчилсан засаглалтай дийлэнх улсад засгийн эрхийг зөвхөн ард түмэн эрхлэнэ хэмээн тусгайлан зааж өгсөн байдаг. Хувь хүний эрх чөлөөний зарчим нь иргэдийн нийгэм болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрхээр баталгаажиж байдаг. Ийм оролцоог бодитой болгохын тулд аливаа ардчилсан улс нь иргэдийнхээ үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй. «Монголын ардчиллын үнэлгээ» (Уб., 2016) шинжээчдийн үнэлгээгээр 59.4 хувь нь «...ардчилал бол ард түмэн төр засгийн удирдлагыг чөлөөт сонгуулиар сонгож, тэгш ёсыг эрхэмлэж, улс төрд ёс суртахууны соёлтой оролцож, эрх баригчидтай тооцоо хийх боломж олгоно»¹ гэжээ. Төрийн шийдвэр боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжилтийг нь хянах бүхий л үйл ажиллагаанд иргэд оролцож, үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэрт саналаа тусгах боломж, нөхцлийг бүрдүүлэх нь ардчиллыг хүртээмжтэй болгох чухал нөхцөл билээ. Гэтэл иргэдийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах албан ёсны ажиллагаанд хангалттай оролцуулж чадахгүй байна. Түүнчлэн өнөөдрийн байдлаар иргэдийн өгсөн санал төрийн байгууллагын гаргасан хууль, тогтоомж, шийдвэрт хэрхэн туссан нь тодорхойгүй, иргэд өөрийн саналын үндэслэлээ тайлбарлах, хамгаалах, шийдвэр гаргагчид иргэдийн бичгэн саналд байгаа ойлгомжгүй зүйлийг асууж, тодруулах, саналын үндэслэлүүдийг нягтлан шалгах боломжгүй байна.

Ардчилал өндөр хөгжсөн улсуудад хууль тогтоох үйл ажиллагаанд төдийгүй парламентаас гүйцэтгэх эрх мэдлийг хянах, захиргааны байгууллагаас хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах болон татвар, байгаль орчин, нийгмийн зэрэг олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн үзэл бодлыг сонсох, саналыг нь тусгах зорилгоор нийтийн сонсгол зохион байгуулах нь ердийн үзэгдэл болжээ.

Өнөөгийн монголын улс төрийн үйл явцын хөгжилд, засаглал эрх мэдлийн харилцаа нь улс төрийн хошуучлагчдын үйл ажиллагаа, үйлдлээс ихээхэн хамаарах болсон. Улс төрийн албан тушаал, эрх мэдэл, эдийн засгийн ашиг сонирхлын зөрчил төр засгийн үйл ажиллагааг гацаах болсон билээ. Хамгийн сүүлийн жишээ гэхэд л эрх баригч намын лидерүүдийн зөрчил УИХ-ын үйл ажиллагааг бойкотчилж, улмаар парламент, төдийгүй засаг төрийн ажил олон сар хоногоор зогссоноор эдийн засаг, ард түмний амьдралд сөргөөр нөлөөлөх болсон. Учир нь улс төрийн хошуучлагчдын зөрчил болон улс төрийн лидерийн хомсдол гэж улс төр судлаачид сүүлийн үед дүгнэх болсон нь эл судалгааны дүнгээс тодорхой нотлогдож буйг харж болохоор байна.

Ардчилсан төрийн үйлдлийн хууль ёсны байдал нь эцсийн дүндээ ардчилсан зөв дэг дээр бус, хуулийн дэг журмаас дээгүүр байдаг ёс суртахууны хүрээнээс үүссэн энэ

¹ Хатанболд О. Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс. /Улс төрийн ухааны доктор (Ph. D)-ын зэрэг горилсон бүтээл. «Адмон» ХХК. Уб., 2016. 94 дэх тал.

тэргүүний эрх, хэм хэмжээн дээр суурилна. Зөвхөн төр л хууль ёсыг сахиулах хүчийг нэгтгэж, зүй зохистой байршуулж¹ чадна. Эдгээр хүч нь улс оронд хууль дээдлэх ёсыг сахиулахад ч зайлшгүй хэрэгтэй. Бид ардчилал, өөрийгөө удирдах ёс, хүний эрхийг дээдлэх ёсыг сахиулан бататгах, мөн түүнчлэн өөр ард түмнийг захирах аливаа оролдлого бол эзэрхийлэх санаархал бус ердөө шилжилтийг хэрэгжүүлэх санааг нотлохын зэрэгцээ төрийг төвхнүүлэх урлаг үндэсний хүч чадлын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг байх болно.

Дээр дурдсан үндэсний хүч чадлыг бэхжүүлэхэд шаардлагатай хариуцлагатай төр гэдэг нь засаглаж байгаа ард түмнийхээ өмнө хариуцлага хүлээж байгаа гэдэгт эрх баригчид нь итгэдэг, ард түмнийхээ ашиг сонирхлыг өөрийнхөөсөө дээгүүр тавьдаг засаглал гэсэн үг. Энэ нь ямар ч хүн хуульд захирагдахаас гадна хамгийн чухал нь нийтийн хууль бүхий санал өгөх эрхтэй цөөнхөөс сонгогддог парламентын баталсан хууль тогтоомжоос бүрдэх улс төрийн хариуцлагын хамгийн эхний хэлбэр бүхий ард түмний өмнөх хариуцлага биш харин нийгмийн зөвшилцлийг илэрхийлсэн уламжлалт хууль болон олигархийн хууль тогтоомжийн өмнө хүлээх хариуцлага байх ёстой² хэмээн Ф.Фукуяама «Улс төрийн тогтолцооны сурвалж» бүтээлдээ онцлон тэмдэглэсэн байна. Түүнийхээр бол, ардчиллын мандал, хуулийн засаглалын мандал хоёр биентэйгээ салшгүй нягт уялдаатай болохыг дурдаад хуулийн засаглал цаашаа улам олон иргэнд хүртээлтэй болон дэлгэрэх нь ардчиллын өөрийнх нь нэг чухал элемент мөн бөгөөд ардчиллын гуравдугаар давалгаа дэгдэн коммунист дарангуйлал нуран сонгуулийн ардчилал гарч ирснээр, үндсэн хуульт төр хувь хүмүүсийн эрхийг хамгаалах болсноор цааш үргэлжлэх алхам³ бий болоход хүргэсэн.

Энэ утгаараа шударга зан, найдвартай байдал, хамтарч ажиллах чадвар, бусдын өмнө үүрэг хүлээх мэдрэмж зэргийг оролцуулан нийгмийн буян хувийн буяныг төлөвшүүлэхэд зарчмын ач холбогдолтой⁴ гэж дүгнэхэд хүргэж байна. Ер нь төрийн хууль бол нийт иргэдэд зориулагдсан байх ёстой, аль нэг нам, хэсэг бүлгийн сонирхолд нийцүүлж зориулсан хуулийг төрийн хууль, улсын хууль гэж үзэх үндэсгүй юм. Төрийн хуулийн оронд намын хууль, өөрөөр хэлбэл, хэсэг бүлгийн эрх ашгийг хамгаалсан, дундажаас хэлбийсэн хууль шургачихаж болохгүй. Түүний хамт, төрийн хууль цаазыг сахиулдаг шүүх засаглал бүрнээ бие даасан байх ёстой. Шүүх эрх мэдэл жинхэнээсээ хараат бус болж чадсан цагт л төрийн хуулийг өрөөсгөлдөхгүй, нугалаа завхрал гаргахгүй, туйлшрахгүй хэрэгжүүлэх үндэс бүрдэнэ.

¹ Фукуяма Ф. Төрийг төвхнүүлэхүй: XXI зууны засаглал, дэлхийн дэг журам. орч. Гомбосүрэн Ц. Нэпко хэвлэлийн газар. УБ., 2014. 142 дахь тал.

² Фукуяама Ф. Улс төрийн тогтолцооны сурвалж: Хүний үүслийн өмнөхөөс Францын хувьсгал хүртэл. орч. Ариунсанаа Т. Нэпко хэвлэлийн газар. УБ., 2014. 401-402 дахь тал //Fukuyama Francis. The Origins of Political Order. 2011//

³ Фукуяама Ф. Улс төрийн тогтолцооны сурвалж: Хүний үүслийн өмнөхөөс Францын хувьсгал хүртэл. орч. Ариунсанаа Т. Нэпко хэвлэлийн газар. УБ., 2014. 511 дэх тал.

⁴ Фукуяама Ф. Итгэлцэл: нийгмийн буян, хөгжин цэцэглэх зам. орч. Гомбосүрэн Ц. Нэпко хэвлэлийн газар. УБ., 2014. 59-60 дахь тал //Fukuyama Francis. Trust: The Social Virtues and the Creation of Prosperity. 1995//

Нөгөөтээгүүр, эл суурь судалгаа нь манай оронд улс төрийн соёлын төлөвшил ямар түвшинд байгааг, хэрхэн илрэн гарч буйг олон нийтийн болон шинжээчийн үзэл бодлыг чанарын болон тоон судалгааны аргыг хэрэглэн, харьцуулан дүгнэснээрээ ихээхэн ач холбогдолтой хэмээн үзэж буй болно.

Тав. Суурь судалгааны төслөөс гарсан санал, зөвлөмж

Улс төрийн соёл бол аливаа улс төрийн систем дэх объектын талаарх үнэт зүйлс, хандлага, үнэмшлийн хуваарилалт хэмээн тодорхойлогддог. Энэ ойлголт маш өргөн хандлагатай бөгөөд түргэн хувьсах хандлага үнэлэмжид биш тодорхой бодлогын дэмжлэг, улс төрчийн рейтинг гэх мэт хүмүүс багаасаа өөриймшүүлдэг удаан хувьсдаг тэрхүү хэм хэмжээ, үнэт зүйлсийг сонирхдог явдал мөн учраас тэдгээр нь **нийгмийн уламжлалт үнэт зүйлс юм.**

Энэ мэтчилэн, ардчиллын талаар хэрэгжиж буй байдалд иргэд санаа бодол доогуур үнэлгээтэй байгаа ч Монгол Улсад ардчилал тохирох эсэхэд иргэд тааламжтай байгаа дүр зураг олон арван судалгааны үр дүнгээс ажиглагддаг нь чухамдаа иргэдийн дунд ардчиллын талаарх мэдлэг хомс, улс орноос хэрэгжүүлж буй үйл ажиллагаа хэрэгжихгүй байгаа нь ардчиллыг дан ганц **эрх, эрх чөлөө мэтээр ойлгож буйтай холбоотой.**

Гэхдээ ардчилсан итгэл үнэмшил хийгээд түүний соёл, практикаас харахад, улс болгон эрт орой хэзээ нэгэн цагт улс төрийн систем бодитоор оршин тогтнож хөгжихийн хэрээр хямрал, бэрхшээл гардаг учиртайг ухамсарлах болно. Чингэснээр тогтвортой ардчилалд хүрэх аялал ямагт шуургад **өртөх нь эргэлзээгүй.**

Нийгэмд тохиолддог ужиг хямралын үед түүнийг арилгахаар манлайлагчид ардчиллыг нураах аюулыг өсгөдөг ч, энэ аажимдаа ардчилсан үндсэн институт дэг журмыг зайлуулахыг шаардах нь ХХ зууны туршид ардчилсан дэглэмүүд унах явдал ердийн үзэгдэл байсаар ирсэнтэй холбоотой. Учир иймд улс төрийн соёлыг бүх шатанд төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа төрийн төвшинд бодлоготойгоор зохион байгуулж хэрэгжүүлэхгүйгээр бодит хөгжил, зөв ёс суртахуун оршин тогтноход хүндрэл учирч байна.

Өнөөгийн байдлаар улс төрийн намууд болон нийгмийн байгууллагууд эл хандлагыг нэр төдий байдлаар авч үзэх нь эцэстээ дээр нэгэнт дурдсанчлан ардчилсан улс төрийн соёлыг хямралд хүргэх эрсдэлтэй. Үүнээс улбаалан, улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагууд, судалгаа шинжилгээний байгууллагууд иргэдийн улс төрийн болон ардчиллын боловсролыг шат дараалалтай системтэйгээр авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тиймээс л, сайн хөгжсөн ардчилал нь ард түмэндээ чиглэсэн, сайн үйл ажиллагаатай улс төрийн намуудаас ихээхэн хамаардаг боловч шинэ ардчилал гэдэг нь шинэ бодлогын зөв шударга хариуцлагын тогтолцоо бүхий нам гэсэн үг юм. Эдгээр намууд нь улс төрийн боловсрол, төрөл бүрийн сонирхлын бүлгийг дайчлан тэднийг төлөөлөх уламжлалт үйл ажиллагаагаа бүрэн гүйцэд явуулж чадахгүй л байгааг харуулж буй. Нөгөө талаар, улс төрийн намуудын дотоод ардчилал, шударга зөв засаглалыг сайжруулах явдал чухлаар тавигдаж байна. Чингэхдээ засаг төрөөс иргэний нийгэм санаа бодлоо илэрхийлэх, зохион байгуулагдах, хөгжлийн үйл явц зэргийг хянахад оролцох, улсын салбарын үйл ажиллагааг хянах үүргийг биелүүлэх бүрэн боломж нээгдэнэ.

Иргэдийн улс төрийн соёл, ардчиллын боловсролыг дээшлүүлэх түншлэлийн сүлжээ байгуулах, зөвлөх үйлчилгээ, нөөц баялгийн ашиглалтын талаар зөвлөл байгуулан сургалт, сурталчилгааны ажлыг эхлэлийг тавьж хэвшүүлэх цаг үеийн шаардлага бидний өмнө сорилт болон тулгарч байна.

Энэ хүрээндээ иргэд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын улс төрийн хүсэл зоригийг дэмжих, сурталчлах, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, нийгмийн бүлэг, ялангуяа эмзэг, гадуурхагдсан хэсгийг дайчлах зэрэгт зориулан эрх зүй, улс төр, институцийн орон зайг бий болгон санаачлан ажиллах ёстой.

Энэхүү хариуцлагатай байдлын үндэс бол иргэдийн итгэл ба нийгмийн тогтвортой үйл ажиллагаа, түүний үр нөлөөг дээшлүүлэх явдал юм. Чингэхийн тулд, судалгааны багийн гишүүд дараах бодлогын зөвлөмжийг авч хэрэгжүүлэхийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах төвшний байгууллагуудад санал болгож байна. Тухайлбал, БСШУСЯ, СЕХ, ШУА, НЗДТГ, иргэдийн болон сонгогчдын боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн, төрийн болон төрийн бус байгууллагуудад дараах багц зөвлөмжийг түгээн дэлгэрүүлэх болно.

1. Ёс зүйн хэм хэмжээ, сургалт, сахилга бат, санхүүгийн сайн менежмент, ил тод байдал, дотоод ардчилал гэх мэт зүйлс бүрэн гүйцэт төлөвшихгүй байгаатай адил хувирч байна. Энэ бол улс төрийн намуудад ардчиллын соёлыг бий болгох нь маш чухал бөгөөд ядаж л намын удирдлагын төлөө нээлттэй, өрсөлдөөнтэй сонгуулийг явуулах, улс төрийн соёл, сэтгэлгээний өндөр ёс суртахуунтай байхыг шаардаж байна.
2. Ардчилсан байгууллагуудыг бэхжүүлэх нь зайлшгүй боловч зөвхөн олон нийтийн идэвхтэй оролцоо болон эрх мэдэлтнүүдийг хариуцлагатай шийдвэр гаргахыг уриалж, хамтын түншлэлийг бий болгон эрчимжүүлэх.
3. «Түгшүүр өгөгч иргэн» нь ардчилсан байгууллагуудыг ажиллуулж, үйл явцыг үргэлжлүүлж байдаг зүйл юм. Доод шатнаас гарсан улс төрийн дарамт нь өөрчлөлт хийхэд хүргэдэг хамгийн үр дүнтэй, гол хүчин зүйл мөн бөгөөд сүүлийн хоёр зууны туршид хүний хөгжилд маш их ахиц дэвшил гарч боолчлох ёсыг халж, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хүлээн зөвшөөрөх, ардчиллын өөрийнх нь дэвшил зэрэг нь дээрээс бэлэглэсэн зүйл биш юм. Ард түмэн өөрсдөө үүнийхээ төлөө тэмцэх шаардлагатай болсон цагт л эл боломж туйлын сайшаалтай хийгээд зориг тэвчээр шаардсан үйл хэрэг болно.
4. Ардчилал, эрх чөлөөний талаарх хэт ерөнхий, гэнэн төсөөлөл, улс төрийн соёлын доогуур төвшингөөс хамаарч эрх зүйт төр, ардчиллын хөгжилд бэрхшгээл, хүндрэл гарч, улмаар гажуудал, завхрал алхам алхамаар газар авах боллоо. Энэ нь өнөөгийн Монгол Улсад иргэний нийгмийн хяналтын үүргийг бэхжүүлж, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх.

5. Иргэний нийгмийн байгууллагуудын ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх, чингэхдээ тэдний үйл ажиллагаанд хариуцлага, ил тод байдлын зарчмыг нэвтрүүлэх явдлыг дэмжих.
6. Төрийн институциудын албан ёсны тогтолцоо бүхий механизмыг түншлэлийн бүх хэлбэрээр зохион байгуулж хөгжүүлэх.
7. Улс төрчдийн мэдлэг боловсрол, төрийн үйл хэргийг удирдан явуулах чадвар, ёс зүйн өндөр соёлыг төлөвшүүлэх, төрийн албаныханы гүйцэтгэх зөөлөн болон хатуу ур чадварыг дээшлүүлэх,
8. Улс төрийн нам, улс төрчдийн ёс суртахууны хэм хэмжээг сахин мөрдүүлэх дадал соёлыг бүрдүүлэх, төрийн бодлого энэ чиглэлээр үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулан дагаж мөрдүүлэх дадлыг эзэмшүүлэх,
9. Улс төрчдийн зөв, шударга манлайлалыг төлөвшүүлж, тэдний үндэсний эрх ашгийнхаа төлөө ажиллах санал санаачлагыг өрнүүлж, үнэнч, хүнлэг чанарыг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй байдлыг бүх шатанд мөрдүүлэх, хариуцлагын хэм хэмжээг чанд баримтлуулах,
10. Хариуцлагын тогтолцоог сайжруулах, улс төрийг мөнгө, санхүүгийн бүлэглэлээс ангижруулж, түүнээс салгах, мэргэшсэн чадварлаг шинж чанарыг өөртөө бүрдүүлсэн шударга, зөв улс төрчдийн хэв маягийг нийгэмд бий болгох,
11. Бүх шатны төлөөллийг үнэн зөв мэдээ мэдээллээр хангаж, ил тод, шударга ардчилсан зарчмыг баримтлах нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд чиглэсэн сурталчилгааны ажлыг системтэйгээр зохион байгуулах,
12. Төрийн албан хаагчид, улс төрийн болон төрийн өндөр албан тушаалтнууд алдаа дутагдал гаргасан бол хуулийн хариуцлага хүлээдэг шударга, ёс зүйн механзм бүхий тогтолцоог бий болгох. Ингэхдээ, тэдний төрд учруулсан аливаа хохиролыг тухан албан хаагч, улс төрчдөөр нөхөн төлүүлдэг ёс зүйн бодит хариуцлагыг бий болгон төлөвшүүлэх.
13. Иргэдийн улс төрийн соёлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн үндэсний хэмжээний кампанит ажлыг төр, иргэний нийгэм-эрдэм шинжилгээний байгууллагуудн түншлэлийн хэлбэрэрэ зохион байгуулж ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудад тусгайлсан хичээлийн эсвэл сургалтын хөтөлбөр боловсруулан сургалт явуулах,
14. Сонгогчдын улс төрийн болон ардчиллын боловсролыг дээшлүүлэх зорилгоор улс төрийн соёлын зөв төлөвшлийг бий болгож бодит амьдралд нийцсэн хяналтын тогтолцоог төлөвшүүлэхийг зөвлөмж болгож байна.

Хавсралт 1. “Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” Суурь судалгааны төслийн үр дүнгийн даалгавар


“Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” нэртэй суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн ШУСс-2017/47 дугаар гэрээний 1 дүгээр хавсралт

д/д	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн биелэлт	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа (он, сар)
1.	Монгол дахь ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, үнэлэмж, үнэ цэнийг өсгөх, улс төрийн ухаалаг сонголт хийхэд нь туслах, оролцооны субъектив хүчин зүйлийг түлхүү судлан тогтооно.	Судалгааны тойм – 1 (20 хуудас)	<p>1. Бид улс төрийн соёлын нийгэмд гүйцэтгэдэг үүргийг тодорхойлж тодорхой үзүүлэлтээр хэмжих зорилгоор шинжлэх ухааны янз бүрийн дэг сургуулийн судалгаа, тодорхойлолтыг авч үзэж харьцуулалт хийсэн. Эл зорилтоо улс төрийн шинжлэх ухааны хүрээгээр хязгаарлаж улс төрийн соёлд юуг хамруулан үзэж байна вэ гэдгээ эхлээд нэрлэвэл судлах зүйл тодорхой болно хэмээн үзсэн. Чингэхдээ, улс төрийн соёлд дараах зүйлийг юуны өмнө хамруулсан. Тухайлбал,</p> <ol style="list-style-type: none"> ¹ иргэдийн улс төрийн мэдлэг. ² Улс төрийн үнэлэмж ³ Төр, улс төрийн байгууллагын үйл ажиллагаа, улс төрийн үйл явдлын талаарх үнэлгээ ⁴ Улс төрийн хүрээ, үйл ажиллагааны үе дэх зан үйл зэргийг хамруулан үзэх судалгааны үзэл баримтлалыг боловсруулсан. <p>2. Хатанболд О. «Ардчилал судлал: онол, арга зүй» (150 ш).14.75хх. Соёмбо принтинг. Уб., 2017.</p> <p>3. Хатанболд О. «Ардчиллыг ойлгохуй ба судлахуй (Монголын жишээн дээр)» (150 ш). 14.16 хх. Соёмбо принтинг. Уб., 2017 зэрэг нэг сэдэвт бүтээл.</p>	2017 он 12 сар
2.	1990-ээд оноос хойшхи иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, энэ хүрээн дэх бэрхшээл сорилт, тулгамдаж буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулна.	Бичил судалгаа – 1 ОНСБ-ын судалгаа - 1	<p>1. Болдбаатар Б. «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд үзүүлэх эдийн засаг, засаглалын зохистой нөлөөллийн асуудал» сэдэвт бичил судалгааг гүйцэтгэсэн.</p> <p>2. «Өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага» сэдэвт олон нийтийн санаа бодлын судалгааг зохион байгуулж, мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх ажлыг гүйцэтгэсэн.</p>	2017 оны 8 сар – 2018 оны 1 дүгээр сар 2018 оны 7-10 дугаар сар
3.	Иргэдийн улс төрийн соёлыг төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, хэтийн төлөв хандлагын талаарх санааг	Экспертийн судалгаа – 1 Судалгааны тайлан – 3	<p>1. «Өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага» сэдэвт олон нийтийн санаа бодлын судалгааны эцсийн тайланг боловсруулсан.</p> <p>2. «Өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага»-ыг тодорхойлох</p>	2019 оны 3 дугаар сар

	дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулна.		<p>зорилгоор өндөр төвшний шинжээчдийн судалгааг 2018 оны 5 дугаар сард зохион байгуулж, шинжээчдийн судалгааны тайланг 11-12 дугаар сард боловсруулсан.</p> <p>3. «Өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага»-ыг тодорхойлох чанарын судалгааг зохион байгуулж, тайланг боловсруулсан.</p> <p>4. «Өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага» сэдэвт судалгааны эцсийн нэгдсэн тайланг боловсруулж, хэвлэн нийтлүүлсэн.</p> <p>5. Иргэдийн улс төрийн соёл, ардчиллын боловсрол, соёл, эрх зүйн соёлын чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүдэл, илтгэл, орчуулгыг дараах байдлаар хийж гүйцэтгэв.</p> <p>2019 он: ЭШӨ – 14 (гадаад - 6, дотоод 8) ЭШИ – 12 (гадаад – 5, дотоод 7) ЭШО – 2 Нэг сэдэвт бүтээл – 1 Судалгааны товхимол - 1 Хамтын бүтээл – 2 (бүлэг 4, зүйл-12) Сурталчилгааны нийтлэл – 3 Редакторласан ном – 2 Номын шүүмж – 2 ХМХ-д өгсөн ярилцлага – 5 Боловсруулсан санал, зөвлөмж – 1 Онол, арга зүйн семинар - 2 Судалгааны анкет – 1 Судалгааны тайлан – 3</p> <p>2018 он: ЭШӨ – 17 (гадаад - 6, дотоод 11) ЭШИ – 13 (гадаад - 2, дотоод 11) ЭШО – 5 Судалгааны анкет – 1</p> <p>2017 он: ЭШӨ – 12 (гадаад - 0, дотоод 12) ЭШИ – 17 (гадаад - 3, дотоод 14) ЭШО – 2 Нэг сэдэвт бүтээл - 2 Илтгэлийн эмхэтгэл – 1 Хамтын бүтээлийн зүйл – 1 ХМХ-д өгсөн ярилцлага - 6</p> <p><i>Бүтээлийн жагсаалтыг хавсаргав.</i></p>	<p>2019 оны 4-5 дугаар сар</p> <p>2019 оны 5 – 12 дугаар сар</p> <p>2019 оны 10 -11 дүгээр сар</p> <p>2019 оны 12 дугаар сар</p> <p>2017-2019 он</p>
4.	«Хөгжил ба улс төрийн соёл» сэдэвт хамтын бүтээлийг хэвлүүлнэ.	Хамтын бүтээл - 1	<p>1. «Монгол дахь улс төрийн соёл: уламжлал ба орчин үе» сэдэвт хамтын бүтээлийн эхний бичилтийг хүлээн авч, хяналтын уншилт хийсэн.</p> <p>2. Хамтын бүтээлийг хэвлүүлсэн..</p>	<p>2019 оны 12 сараас 2020 оны 2 дугаар сар</p> <p>2020 оны 3 дугаар сар</p>

5.	«Хөгжил, нийгэм, бие хүнийн зан төлөв, үйл байдалд улс төрийн соёлыг хэрэгжүүлэх боломж, арга зам» судалгааны нэгдмэл зөвлөмж боловсруулсан.	Зөвлөмж	«Монгол дахь улс төрийн соёл: уламжлал ба орчин үе» сэдэвт хамтын бүтээлийн хүрээнд хийсэн судалгааны үр дүнд тулгуурласан шинжилгээ бүхий зөвлөмжийг салбар хоорондын уялдааг тодруулах зөвлөмжийг боловсруулсан. Зөвлөмжийг хамтын бүтээлд тусгайлан хэвлэх болно.	2019 он 12 дугаар сар
6.	Нийлүүлсэн нийт бүтээгдэхүүн	144 бүтээгдэхүүн	Үүнийг ангилан үзвэл: ЭШӨ – 43 (гадаад - 12, дотоод 31) ЭШИ – 42 (гадаад – 10, дотоод 32) ЭШ-ний орчуулга – 9 Нэг сэдэвт бүтээл – 3 Судалгааны товхимол - 1 Хамтын бүтээл – 2 Хамтын бүтээлийн зүйл-13 Сурталчилгааны нийтлэл – 3 Редакторласан ном – 2 Номын шүүмж – 2 ХМХ-д өгсөн ярилцлага – 11 Боловсруулсан санал, зөвлөмж – 1 Онол, арга зүйн семинар - 2 Судалгааны анкет – 2 Судалгааны тайлан – 3	

Хавсралт 2. “Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” Суурь судалгааны төслийн үр дүнгийн даалгаврын дагуу хэвлэн нийтлүүлсэн бүтээлийн хураангуй танилцуулга




Энэхүү хамтын бүтээл нь Монгол дахь улс төрийн соёлыг түүхэн уламжлал ба орчин үетэй нь харьцуулан авч үзэж, Монголын улс төрийн соёлын өнөөгийн төлөв байдал, улс төрийн соёлын орчин үеийн хэв маяг, нийгмийн үүрэг, үр нөлөө, улс төрийн болон эрх зүйн соёлын харилцан хамаарал болон цаашдын хөгжлийн чиг хандлага зэргийг иж бүрэн байдлаар гарган харуулахыг хичээсэн болно. Хамтын бүтээл 4 бүлэг, 12 зүйл, дүгнэлт, зөвлөмж, товч хураангуй, ном зүй хэсгээс бүрдэнэ.

Хэвлэсэн газар: «Соёмбо принтинг». ХХК. Уб., 2020. 26.5 хх.

Редактор: Баасансүрэн Д., Хатанболд О.,

Рецензи өгсөн: Ганболд Ц, (МУИС), Төгөлдөр Я (ШУТИС)



Судалгааны нэгдсэн тайланд Монголын нийгмийн улс төрийн соёлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг тодруулж, улмаар улс төрийн соёлын талаарх орчин үеийн онолд тулгуурлан дүгнэлт гаргах, таамаглалаа шалгах, онолын шинжтэй шинэ санааг нотлохыг зорьсон болно. Мөн өнөөгийн Монголын улс төрийн соёл хийгээд түүний төлөв байдал, чиг хандлага, төсөөллийг иргэдийн төсөөлөл, шинжээчдийн үнэлгээ, чанарын судалгааны шинжилгээгээр дамжуулан иргэдийн улс төрийн соёлыг төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг тодорхойлж, энэ хүрээний хэтийн төлөв хандлагыг тодорхойлох оролдлого хийснээрээ эл дурдсан судалгаануудын үр дүн чиглэгдсэн.

Редактор: Баасансүрэн Д., Хатанболд О., Хишигдаваа А., Энхболд Д.


«Тод бичиг» ХХК. Уб., 2019. 28.6 хх



Энэхүү бичил судалгааны товхимол д улс төрийн үйл явцын хөгжилд үзүүлж буй эдийн засаг, засаглалын зохистой нөлөөллийг үнэлэхэдээ хүний хөгжлийн индексийн өсөлт нь зөвхөн нэг хүнд ногдох, ДНБ-ний өсөлтөөр хангагдаж байгаа бөгөөд дундаж нас, боловсролын индекс нь нэг түвшинд байгаа учраас хүмүүн капитал бүрэлдэх үндсэн хүчин зүйлийн нэг болсон хүн амын амьдралын түвшин, чанарын судалгааг илүү нарийн түвшинд бодитой гаргах шаардлага тулгарч буйг онцолсон. Хүмүүн капиталын хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгэрээ тооцож, цаашид тогтвортой хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогод тусгай зайлшгүй шаардлага буйг төр засгийн удирдлагын анхааралд хүргэхийг зорьсон Товхимол 3 бүлэг, 8 зүйл, дүгнэлт, ном зүй хэсгээс бүрдэнэ.


Зохиогч Болдбаатар Б., Ред. Баасансүрэн Д., Хатанболд О. «Тод

бичиг» ХХК. Уб., 2019. 12.1 хх



Ардчилал гэдэг нь өөрчлөгдөж хувиршгүй мэдээж үнэний эмхэтгэл биш, харин хувь хүмүүс, байгууллагууд санал бодлоо уралдуулан, харилцан буулт хийх замаар боловсронгуй биш ч гэсэн үнэнд хүрэх механизм болох учиртай. Бидний итгэж, найдаж бас төсөөлдөгчлөн ардчилал нь ажил хэрэгч бөгөөд амьдралд дөт байдаг аливаа асуудлыг шийдэхдээ аль нэг үзэл сурталыг турших биш харин түүнийг жинхэнэ амьдрал дээр туршиж гэмээ нь түүний ашигтай, ашиггүйг нь үзэх бодит үнэ цэнэтэй авч бас хэврэг, нандин эрхэмлэл юм. Үүгээрээ ардчилал бол нийгмийг шинэчлэлд хүргээд зогсохгүй ардчилсан тогтолцоо нь алдаа дутагдал гаргасан эсвэл хэрэгцээгүй болсон бодлого, улс төрчдийг тогтмол, тайван аргаар халж өөрчлөх боломж олгож нийгмийн бүлгийн болон үе хоорондын шинэчлэлийг хэрэгжүүлдэг. Энэ утгаараа бүх нийтийн хэрэгцээ, жирийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахдаа ардчилсан төр засаг бусад төрлүүдээсээ илүү юм.

*Зохиогч Хатанболд О., «Соёмбо принтинг» ХХК. Уб.,
2019. 34.5 хх*



Монголд хийгдсэн судалгааны үр дүн хийгээд монголын ардчиллын мөн чанар, төлөвших үйл явцын онцлогийг гадаад ертөнцөд таниулахыг хичээсэн эрдэм шинжилгээ, судалгааны оролдлоо юм. Энэ зорилгын хүрээнд II ботид (i) *Ардчилал ба улс төрийн соёлын төлөвшил*; (ii) *Монголын ардчилалд тулгарч буй сорилт бэрхшээлийг тодорхойлохыг зорьсон* гадаад хэл дээр хэвлүүлсэн өгүүлүүдийг багтаасан хэсэг; (iii) *Ардчиллын болон улс төрийн соёл, иргэний нийгэм, авлига, улс төрийн нам зэрэг орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны шинэ хандлагын талаарх* гадны сулаачдын туурвисан бүтээлийг орчуулах байдлаар мэдлэг түгээхийг зорьсон эрдэм шинжилгээний орчуулгыг багтаасан юм. Өөрөөр хэлбэл, адчилал бол монголын нийгмийн өөрчлөлтийн сонирхолтой мөртлөө ээдрээтэй асуудал бөгөөд түүний төлөвшил хийгээд гарсан өөрчлөлтийг судалгааныхаа чиглэл болгон сонгон судалж, эл нарийн төвөгтэй үзэгдэл үйл явцын талаарх ойлголт, хандлагыг өөрийн судалгааны хүрээнд бичиж нийтлүүлсэн ардчиллын онолын болоод практикийн харьцуулсан аналитик шинжилгээ бүхий гадаад дотоодод хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад хэлэлцүүлсэн илтгэл болон эрдэм шинжилгээний орчуулга (*англи хэлнээс монгол хэлэнд*) зэргийг эмхэтгэсэн болно.

*Зохиогч Хатанболд О., «Соёмбо принтинг» ХХК. Уб.,
2019. 39 хх*



Эл нэг сэдэвт бүтээл нь 3 бүлэг, 8 зүйлээс бүтсэн, нийт 200 нүүр, 12.5 хх юм. Бүтээл бүхэлдээ монголын нийгмийн өөрчлөлтийн сонирхолтой мөртлөө ээдрээтэй асуудал болох ардчилал, ардчиллын төлөвшил, түүнд гарсан өөрчлөлтийг чиглэл болгон сонгож, эл нарийн төвөгтэй үзэгдэл үйл явцын талаарх ойлголт, хандлагыг өөрийн судалгааны хүрээнд ардчиллын онолын болоод практикийн харьцуулсан судалгааны аналитик шинжилгээг ардчиллыг сонирхон судлагчид, их дээд сургуулиудын магистр, докторантурт суралцагчид болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг бүгдэд зориулан гаргахаар зорьсон болно. Судалгааны үндсэн хэрэглэгдэхүүнээ ардчиллын чиглэлээр үндэсний болон олон улсын төшинд хийгдсэн томоохон судалгааны үр дүнд харьцуулалт шинжилгээ боловсруулалт хийсний зэрэгцээ өөрийн хамгаалсан сэдвийн хүрээнд хийсэн шинжээчдийн асуулгын дүнг түлхүү ашигласан.

*Зохиогч Хатанболд О., «Соёмбо принтинг» ХХК. Уб.,
2017. 14.75 хх*



Эл нэг сэдэвт бүтээл нь 3 бүлэг, 8 зүйлээс бүтсэн, нийт 200 нүүр, 12.5 хх юм. Бүтээл бүхэлдээ монголын нийгмийн өөрчлөлтийн сонирхолтой мөртлөө ээдрээтэй асуудал болох ардчилал, ардчиллын төлөвшил, түүнд гарсан өөрчлөлтийг чиглэл болгон сонгож, эл нарийн төвөгтэй үзэгдэл үйл явцын талаарх ойлголт, хандлагыг өөрийн судалгааны хүрээнд ардчиллын онолын болоод практикийн харьцуулсан судалгааны аналитик шинжилгээг ардчиллыг сонирхон судлагчид, их дээд сургуулиудын магистр, докторантурт суралцагчид болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг бүгдэд зориулан гаргахаар зорьсон болно.

Судалгааны үндсэн хэрэглэгдэхүүнээ ардчиллын чиглэлээр үндэсний болон олон улсын төшинд хийгдсэн томоохон судалгааны үр дүнд харьцуулалт шинжилгээ боловсруулалт хийсний зэрэгцээ өөрийн хамгаалсан сэдвийн хүрээнд хийсэн шинжээчдийн асуулгын дүнг түлхүү ашигласан.

*Зохиогч Хатанболд О., «Соёмбо принтинг» ХХК. Уб.,
2017. 14.16 хх*

Хавсралт 3. «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» Суурь судалгааны төслийн үр дүнг олон нийтэд түгээсэн байдал

f t i y

НҮҮР	УЛС ТӨР	ЭДИЙН ЗАСАГ	НИЙГЭМ	ДЭЛХИЙ	ТЕХНОЛОГИ	COVID-19	АМЬДРАЛ	БИЗНЕС	БОЛОВСРОЛ	1072	C
------	---------	-------------	--------	--------	-----------	----------	---------	--------	-----------	------	---

PEAK TODAY ӨЧИГДӨР 2

О.Хатанболд: Бид улс төрийн соёлын эрсдэлтэй, зааг үе дээрээ байна

Хэрвээ нэр дэвшигч мөнгө өгдөг, түүнийг нь авдаг сонгогчидтой бол тухайн улсын улс төрийн соёл доошилж л байна гэсэн үг



peak

САНАЛ БОЛГОХ МЭДЭЭ

-  2020 оны зургаадугаар сард цаг агаар ямар байх вэ
-  Ц.Эрдэнэбаяр: А92 бензинийг 2020 он дуустал Улаанбаатарын хэмжээнд 1320-1400 төгрөгөөр борлуулна
-  Хүлээлт үүсгэсэн 1072 ширхэг хувьцааны ногдол ашиг үлгэр болов уу
-  Д.Нямхүү: Дахин дөрвөн хүн эдгэрч, өнөөдөр ХӨСҮТ-өөс гарлаа

 **НИЙТЭЛСЭН Ц.ЦЭРЭНДОЛГОР** 2020-05-25 10:03
1 МИН ҮНШИХ

 Facebook 2  Twitter  LinkedIn  More 2


ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, улс төрийн ухааны доктор (Ph.D) О.Хатанболдтой улстөрийн соёл, сонгогчийн боловсрол сэдвээр ярилцлаа.

peak™

НҮҮР УЛС ТӨР ЭДИЙН ЗАСАГ НИЙГЭМ ДЭЛХИЙ ТЕХНОЛОГИ COVID-19 АМЬДРАЛ БИЗНЕС БОЛОВСРОЛ

1072 АМЬДРАЛ ЭДИЙН ЗАСАГ

Монгол дахь улс төрийн соёл, уламжлал, орчин үе



**МОНГОЛ ДАХЬ
УЛС ТӨРИЙН СОЁЛ:
УЛАМЖЛАЛ, ОРЧИН ҮЕ**

САНАЛ БОЛГОХ МЭДЭЭ

- 2020 оны зургадугаар сард цаг өнгөрчид байгаа
- Ц.Дорноддор АРЗ Бичигийг 2020 он сардтай Лийвдөөрчин санхүүгчид 1000-1000 нэрлээр баруулах
- Хувьтат хувьцаа 1072 ширээт зургадугаар нэрлэлтэй хувьцаа болж уу
- Д.Минзуу Дорноддор АРЗ Бичигийг 2020 он сардтай Лийвдөөрчин санхүүгчид 1000-1000 нэрлээр баруулах

НИЙТЭЛЭН ХОРОНГ
2 МИЛ УНШИЖ

Facebook Twitter LinkedIn More 1

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» (2017-2019) сэдэвт суурь судалгааны төслийн үр дүн болгож «Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе» хэмээх хамтын бүтээлийг уншигч Танаа толилуулж байна.

Суурь судалгааны төслийн зорилго нь 1990-ээд оноос хойшхи иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүрэлдэх нэгтгэн дүгнэж, энэ хүрээнд улс төрийн соёлыг түлгэмдэн буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулах, иргэдийн улс төрийн соёлын төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулах явдал байв. Судалгааныхаа зорилгыг биелүүлэхийн тулд манай судлаачдын баг Монголын нийгмийн улс төрийн соёлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг боловсруулж, улмаар улс төрийн соёлын талаарх орчин үеийн онолд тулгуурлан дүгнэлт гаргах, таамаглалаа шалгах, онолын шинжтэй шинэ санаа дэвшүүлэхийг зорьсон болно.

«Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын

← → ↻ https://ip.ac.mn/?id=830913

Apps Bookmarks Amarjargal R Open Journal of Philo Open Journal of Polit Bolor Dictionary Google Translate Munkh-Erdene L

📅 2020-05-05 02:26

«Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе» хэмээх хамтын бүтээлийн тухай товч танилцуулга

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» (2017-2019) сэдэвт суурь судалгааны төслийн үр дүн болгож «Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе» хэмээх хамтын бүтээлийг уншигч Танаа толилуулж байна.




**МОНГОЛ ДАХЬ
УЛС ТӨРИЙН СОЁЛ:
УЛАМЖЛАЛ, ОРЧИН ҮЕ**

Суурь судалгааны төслийн зорилго нь 1990-ээд оноос хойшхи иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүрэлдэх нэгтгэн дүгнэж, энэ хүрээнд улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулах, иргэдийн улс төрийн соёлын төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулах явдал байв. Судалгааныхаа зорилгыг биелүүлэхийн тулд манай судлаачдын баг Монголын нийгмийн улс төрийн соёлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг боловсруулж, улмаар улс төрийн соёлын талаарх орчин үеийн онолд тулгуурлан дүгнэлт гаргах, таамаглалаа шалгах, онолын шинжтэй шинэ санаа дэвшүүлэхийг зорьсон болно.

«Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын

Хавсралт 4. Суурь судалгааны төслийн гүйцэтгэх ажлын календарьчилсан төлөвгөөний хүрээнд 2019 онд хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (Төслийн гүйцэтгэгч тус бүрээр)


Төслийн багийн гишүүдийн хэвлэн нийтлүүлсэн болон төслийн техникийн ажлын даалгаварт заасан хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг тоон утгаар илэрхийлвэл дараах зураглал гарч байна.



Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтыг төслийн багийн гишүүд тус бүрээр гаргасан дараах жагсаалтаар дэлгэрэнгүй танилцуулж байна.

i. Нэг сэдэвт бүтээл- 1

- 1.Хатанболд О. «Монгол дахь ардчиллын мөн чанар, төлөвших үйл явцын онцлог» (эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл) I, II боть. Уб., 2019




Ардчилал гэж чухам юуг хэлэх талаар бидний ихэнх нь урьд нь хэзээ ч энэ асуултанд тодорхой хариулт болох зүйлийг томъёолох гэж үзэж байгаагүй бөгөөд «ард түмэн засгийн эрх барих» гэдгээс цааш хэтэрдэггүй бөлгөө. Гэтэл наанадаж «ард түмэн» гэж хэнийг (юуг хэлэх вэ?) ард иргэд «засгийн эрх барина» гэдэг нь удирдлагыг хэрхэн яаж хэрэгжүүлэхийг хэлэх вэ? гэсэн асуултуудыг тодруулахыг өнөөдөр хүртэл бид эрэлхийлсээр байна.

Угтаа ардчилал бол түүхийн бэрхшээл, сорилт цаг үеийг туулан хөгжиж боловсорсон үйл ажиллагаа, дэг журмын арга хэмжээ юм. Нэг үгээр хэлбэл, ардчилал гэдэг нь эрх чөлөөг хуульчлан баталгаажуулахыг хэлж буй тул орчин үеийн төр, нийгмийн хөгжил дэх хамгийн чухал асуудлууд бүгд л ардчилал, ардчилсан зарчимтай шууд холбогддог. Эл

утгаараа ардчилал нь өөрийн тогтносон аль ч үедээ хамтын шийдвэр гаргахад бүх нийтийн хяналтыг тогтоох, энэхүү хамтын хяналтад бүгд эрх тэгш байдалтай оролцох гэсэн хос зарчмыг агуулна. Тиймээс зөв, шударга шийдвэр хэдий чинээ амьдралд хэрэгжинэ, бид түүнийг төдий чинээ ардчилсан гэж үзэж, бас хэлж болох юм. Нөгөө талаар ардчилал бол нээлттэй мэтгэлцээн, ятган үнэмшүүлэх, харилцан буулт хийхэд тулгуурладаг бидний өдөр тутмын ардчилсан зарчим бүхий шударга үйл ажиллагаа юм. Тэгэхлээр мэтгэлцээний тухай ардчилсан хариуцлагатай бодлогын ихэнх асуултуудад үзэл бодол, ашиг сонирхлын зөрүү байдаг авч мэтгэлцэгч талуудын аль нь ч энэхүү зөрүүнүүдийг илэрхийлэн гаргах, сонсох эрхтэй. Тиймээс ардчилалд нийгэм дэх хүмүүсийн олон янзын үзэл, олон ургальч байдал төдийгүй иргэдийн эрх тэгш байдлыг урьдаас тооцсон таамаглал байх учиртай. Энэ мэт олон янзын байдал илэрхийлэгдээд ирэхэд үүсэх ялгааг шийдвэрлэх ардчилсан арга бол хүчээр тулгах эсвэл эрх мэдлээ нотлон харуулах бус харин ятган үнэмшүүлэх, харилцан буулт хийх арга юм. Чингэхлээр ардчилал бол хий хоосон яригчдын мухлаг бус харин бодлогыг хүлээн зөвшөөрүүлэх олон нийтийн мэтгэлцээнийг өрнүүлэгч талбар буюу.

Ардчилал гэдэг нь өөрчлөгдөж хувиршгүй мэдээж үнэний эмхэтгэл биш, харин хувь хүмүүс, байгууллагууд санал бодлоо уралдуулан, харилцан буулт хийх замаар боловсронгуй биш ч гэсэн үнэнд хүрэх механизм болох учиртай. Бидний итгэж, найдаж бас төсөөлдөгчлөн ардчилал нь ажил хэрэгч бөгөөд амьдралд дөт байдаг аливаа асуудлыг шийдэхдээ аль нэг үзэл сурталыг турших биш харин түүнийг жинхэнэ амьдрал дээр туршиж гэмээ нь түүний ашигтай, ашиггүйг нь үзэх бодит үнэ цэнэтэй авч бас хэврэг, нандин эрхэмлэл юм. Үүгээрээ ардчилал бол нийгмийг шинэчлэлд хүргээд зогсохгүй ардчилсан тогтолцоо нь алдаа дутагдал гаргасан эсвэл хэрэгцээгүй болсон бодлого, улс



төрчдийг тогтмол, тайван аргаар халж өөрчлөх боломж олгож нийгмийн бүлгийн болон үе хоорондын шинэчлэлийг хэрэгжүүлдэг. Чингэхдээ ардчилсан бус дэглэмийн үед шаардлагатай, хүч чадалтай боловсон хүчнийг шахан зайлуулснаас үүдэн гардаг шиг томоохон төрийн хямрал үүсгэхгүйгээр шинэчлэлийг хийх чадвартай. Тиймээс эрх тэгш байдлын зарчимд төр засгийн бодлогоор хүмүүсийн ашиг сонирхолд адил тэгш хандахыг шаардаад зогсохгүй тэдний үзэл бодол ч адил тэгш үнэ цэнэтэй байхыг шаарддаг. Энэ утгаараа бүх нийтийн хэрэгцээ, жирийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахдаа ардчилсан төр засаг бусад төрлүүдээсээ илүү юм.

Чухам иймийн тул, 1990-ээд оноос эхлэн Монгол орон улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт нэгэн зэрэг шинэчлэл явуулж, бүс нутагтаа

ардчилсан хөгжлийн загварыг харьцангуй тогтвортой, тайван замаар хөгжүүлж буй улс бөгөөд чингэхдээ улс төр, эдийн засгийн шинэтгэлийг ядуу буурай оронд нэгэн зэрэг хийх нь, тэр тусмаа Азийн орны явах зам биш гэсэн ойлголтыг эвдэж чадсан юм.

Монгол оронд өрнөсөн ардчиллын үйл явцаар манай нийгэмд улс төрийн үзэл бодол, иргэний ашиг сонирхол, улс орноо хөгжүүлэхэд оролцох арга хэлбэр зэргээрээ ялгаа бүхий нийгмийн бүлгүүд үүсэн бий болсноороо монголчууд өөрсдийн үзэл баримтлал, итгэл үнэмшлээ дагасан улс төрийн үйл ажиллагаа явуулах, олон намын тогтцолоо цоо шинээр бүрэлдэн тогтох чухал үйл явцын эхлэлийг тавьсан юм. Энэ үйл явцын тусгал болж түүнтэй нягт холбоотойгоор монголын нийгмийн улс төрийн амьдралд олон ургалч ардчиллын хэлбэр хөгжиж, ардчилсан үйл явцын өрнөл, нийгмийн улс төрийн амьдралын шинэчлэл, өөрчлөлтийн агуулгыг тодорхойлох болсон.

Монголчууд ардчилал, эрх чөлөөнийхөө ололтоор бахархахын зэрэгцээ түүний ардчилах үйл явцыг баруунжих гэсэн үгээр үл ойлгохын сацуу сайн муугаа нээлттэй хэлэлцдэг хэдий авч, ардчиллын соёлыг бэхжүүлэн дэлгэрүүлэх, ялангуяа ардчиллын боловсрол, залуучуудын идэвхийг дээшлүүлэх, авлигатай тэмцэх зэрэг асуудалд үе үеийн төлөөлөл хоорондын яриа хэлэлцээг эрчимжүүлэх, залуучууд ардчиллын үзэл санааг тууштай дэмжих, үндэснийхээ соёл, онцлогт хэрхэн нийцүүлэн хөгжүүлэх талаар өөрсдийн санаа бодол, туршлагаасаа хуваалцах боломж бололцоо өнөөдрийг хүртэл хангалттай бус байна.

Бидэнд ардчиллын талаар бүхэнд нийцэх хэт ерөнхий, улс орон бүрд таарч сценари, жор болохуйц тийм загвар байх боломжгүйг зөвшөөрч байгаа боловч орчин үеийн ардчилал, ялангуяа төлөөллийн ардчиллын (Роберт А.Даль) тулгуур үзэл санаа, үндсэн зарчим, гол нөхцөл, шаардлагыг тодруулахад ардчиллын суурь онолуудын судалгаа чухал гэж үзсэн бөлгөө. Чухам иймийн тулд, Монгол Улсад ардчилсан хөдөлгөөн үүсэн байгуулагдсанаас хойш эдүгээ 30 жил өнгөрсөн буй. Хэдийгээр монголчууд бид ардчилалд шилжин орсноос хойш монголын ардчилал бэхжиж, тогтворжиж чадсан эсэхийг

тодруулахыг зорин олон жилийн судалгаа хийж, түүний мөн чанар хаана оршин буйг олж танихын төлөөх эрэлхийллийн явцад эргэцүүлэн бодож туурвисан эрдэм шинжилгээний өгүүллүүдээ эмхэтгэж энэхүү бүтээлдээ багтаасан болно.

Өнөөдөр ардчиллын тухай хагас сая гарсан тооны тодорхойлолт байдгийг судлаачид тэмдэглэсэн боловч шинжлэх ухааны хувьд нэг мөр тогтож чадаагүй байгааг бас онцолсон буй. Толилуулан буй бүтээлд ардчиллын тухай монголчуудын ойлголтын агуулга тодорхой бодит кейс дээр хэрхэн хэрэгжиж буйг болон Монгол дахь ардчиллын мөн чанар, төлөвших үйл явцын онцлог, тэдгээрийн талаарх иргэдийн ойлголт, төсөөллийн өөрчлөлтөд үнэлгээ хийх судалгааны ойлголт, үзэл баримтлалын талаар судлаачийн цуглуулсан мэдээлэл, судалгааны баримтад түшиглэн гаргахыг хичээн бүтээлийн эхний эмхэтгэлээ (i) *Ардчилал: Монголчуудын улс төр, төр ёсны уламжлалт сэтгэлгээ ба орчин үе*; (ii) *Монголын нийгэм ба ардчилал, ардчилсан засаглалын төлөв байдал*; (iii) *Ардчилал бол оролцоо хэмээх гурван үндсэн хэсэгт багтаасан болно*.



Мөнхүү эрэл хайгуулын өөрийн судалгааны үндсэн чиглэл болгон 2000 оноос хойш ардчиллын энэхүү үйл явцын төлөвшил, илрэл ямар байх ёстой юм бол гэлгийг сонирхон судалсаар ирсэн. Чингэхдээ ардчиллыг дэмжин хөгжүүлэхэд тулгарч буй нөхцөл байдлыг ухаж ойлгох, түүний учир шалтгаан, үр дагаврыг нээн танихын тулд олон жилийн судалгаа, тасралтгүй эрэл хайгуул хийх шаардлагатайн дээр дэлхий дахинд бидний авч хэрэгжүүлж ирсэн ардчиллын ирээдүй бидэнд хэрхэн харагдаж буйг бид ухамсартайгаар судлах учиртай.

Монголд хийгдсэн судалгааны үр дүн хийгээд монголын ардчиллын мөн чанар, төлөвших үйл явцын онцлогийг гадаад ертөнцөд таниулахыг хичээсэн эрдэм шинжилгээ, судалгааны оролдлого юм. Бидний мэдэхээр ардчилал дэлхийн даяар хэдэн арван мянган жилийн түүхтэй болохыг олон хүн бичиж тэмдэглэсэн бий. Харин Монголд ардчилал хэрхэн оршин тогтнож буйг энэхүү эмхэтгэлдээ багтаахыг хичээсэн юм. Түүнчлэн өөрийн анхдагч мэргэжлийн давуу талыг ашиглан гадаадад хэвлэгдсэн шилдэг бүтээлүүдийг монголчуудад танилцуулж шинэ арга хандлагыг олж таних боломжийг бага ч болов бүрдүүлэх гэсэн чинхүү эрмэлзлийн хүрээнд гадаад хэлнээс танин мэдэхүйн хийгээд шинжлэх ухааны тухайлсан зорилтот бүтээлээс орчуулга хийж бусдад таниулж, мэдүүлээд зогсохгүй мэдлэгийг хуваалцахыг зорьж ирсэн маань эл бүтээлийн нэгээхэн хэсэг болсон орчуулгаас та бүхэн бэлхнээ харна.

Энэ зорилгын хүрээнд II ботид (i) *Ардчилал ба улс төрийн соёлын төлөвшил*; (ii) *Монголын ардчилалд тулгарч буй сорилт бэрхшээлийг тодорхойлохыг зорьсон* гадаад хэл дээр хэвлүүлсэн өгүүллүүдийг багтаасан хэсэг; (iii) *Ардчиллын болон улс төрийн соёл, иргэний нийгэм, авлига, улс төрийн нам зэрэг орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны шинэ хандлагын талаарх* гадны сулаачдын туурвисан бүтээлийг орчуулах байдлаар мэдлэг түгээхийг зорьсон эрдэм шинжилгээний орчуулгыг багтаасан юм. Өөрөөр хэлбэл, ардчилал бол монголын нийгмийн өөрчлөлтийн сонирхолтой мөртлөө ээдрээтэй асуудал бөгөөд түүний төлөвшил хийгээд гарсан өөрчлөлтийг судалгааныхаа чиглэл болгон сонгон судалж, эл нарийн төвөгтэй үзэгдэл үйл явцын талаарх ойлголт, хандлагыг өөрийн судалгааны хүрээнд бичиж нийтлүүлсэн ардчиллын онолын болоод практикийн харьцуулсан аналитик шинжилгээ бүхий гадаад дотоодод хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад хэлэлцүүлсэн илтгэл болон эрдэм шинжилгээний орчуулга (*англи хэлнээс монгол хэлэнд*) зэргийг эмхэтгэн их дээд сургуулиудын магистрантур, докторантурт суралцагчид болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг бүгдэд зориулан гаргахаар зорьсон минь Монгол Улсад ардчилсан хөдөлгөөн үүссэний 30 жилийн ойтой тохиож буйгаар онцлогтой, бас билэгшээлтэй хэмээн үзмүй.

ii. Товхимол-1

1. Болдбаатар Б. «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд үзүүлэх эдийн засаг, засаглалын зохистой нөлөөллийн асуудал» (бичил судалгааны товхимол). Редактор. Баасансүрэн Д., Хатанболд О. Тод бичиг ХХК. Уб., 2019. 12.1 хх



“Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” сэдэвт суурь судалгааны төслийн хүрээнд Монголын улс төрийн үйл явцын хөгжилд үзүүлэх эдийн засаг, засаглалын зохистой нөлөөллийг үнэлэхэд оршино.


Эдүгээ Монгол улс эдийн засаг, санхүү, засаглалын ноцтой хямралд орж, улс төрийн хийрхэлд нэрвэгдэн, нийгэмд нь хариуцлага, шударга ёс, ёс суртахууны эрүүд бус уур амьсгал бий болжээ. Эмзэг бөгөөд өвөрмөц байгаль орчин нь цаашдаа улс орон, хүн ардынхаа эрх ашигт сөргөөр нөлөөлж, үйлдвэрлэл, эдийн засаг, мал аж ахуй, газар тариалангийнхаа ирээдүйн хөгжилд саад бэрхшээл учруулж болохуйцаар хувисан өөрчлөгдөөд байна. Түүнчлэн дэлхий нийтийн байдал таагүй болж байгаа, сүүлийн жилүүдэд бий болж буй шинжлэх ухааны шинэ онол, хандлага, Монголчуудын уламжлалт соёл, сэтгэлгээний өөрчлөлтийн шинж байдал зэрэг нь улс орныхоо хөгжлийн шинэ номлол боловсруулж дэвшүүлэх зайлшгүй шаардлагатай болгож байгаа нь энэхүү судалгааны ажлын ач холбогдлыг тодорхойлж байна гэж үзэж болох юм. Юуны түрүүнд яагаад хямралд хүрэв? гэдгийг тодорхойлж байж, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж буй шалтгааныг судлах шаардлагатай билээ.

Манай орон эдийн засаг, санхүүгийн ноцтой хямралд орсныг, нэгдүгээрт, дэлхийн зах зээл дээр эрдэс баялаг, түүхий эдийн үнэ унасантай холбон тайлбарлаж болно. Гэхдээ зарим судлаачдын үзэж буйгаар энэ бол “Голланд өвчин”-ий зөвхөн эхлэл төдий байсан, цаашид энэхүү хямрал улам лавших төлөвтэй байна; хоёрдугаарт, төр, засгийн удирдлага эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж чадахуйц нэмүү өртөг бүтээх үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж чадаагүйгээс улбаалан нийгмийн хөгжлийг урагшлуулах засаглалын чадавх хэтэрхий сул байна;

зуравдугаарт, мөн л засаглалын эдийн засгийн бодлого буруу байсантай холбоотойгоор түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан улсын төсөв түр хугацаагаар огцом нэмэгдсэн мөчлөгийн үеэр “хүний хөгжил” нэрээр баахан мөнгө үр дүнгүй тарааж, “бүтцийн өөрчлөлт” нэрээр олон тооны яам, агентлаг байгуулан, орон тоог их хэмжээгээр нэмэгдүүлж, үрэлгэн байдал газар авсан; дөрөвдүгээрт, төгрөгийн валюттай харьцах ханш огцом унасан, гадаад зээл, бондын хөрөнгийг зүй зохистой зарцуулж чадаагүйн улмаас тэдгээрийн эдийн засгийн үр өгөөж бага байсан, бодит эдийн засгийн оновчтой бүтцийг бий болгоогүй, олонтаа солигдсон Засгийн газрын бодлогын залгамж чанар алдагдсан нь урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж чадаагүйг харуулж байна. Монгол Улсын Их Хурлаас 2005 онд Мянганы хөгжлийн зорилтуудыг баталж, “Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008-2021 он)”-ыг 2008 онд баталсан хэдий ч Ардчилсан нам засгийн эрхэнд гарсан 2012-2016 онд энэхүү цогц бодлогыг хэрэгжүүлэх талаар ямар ч арга хэмжээ аваагүй нь улс төрийн намууд төрийн дээр гарч, манай орны улс төрийн тогтолцоо засаглалын хямралд орсны тод жишээ юм. Үүнийг, нэгдүгээрт, тогтвортой хөгжлийн урт хугацааны үзэл баримтлалыг оновчтой тодорхойлолгүй сонгуулийн дөрвөн жилийн мөчлөгт баригдсаар ирсэнтэй холбон тайлбарлаж болно; хоёрдугаарт, урт хугацааны хөгжлийн бодлого нь манай орны уламжлалт соёл, бодит байдалд тулгуурлаагүй, гадаадын ижил төстэй баримт бичгүүдийн үзэл баримтлал, зарчмын тааруухан хуулбар болсон, тунхаглалын шинжтэй, уялдаа холбоо сул, хэт ерөнхий төдийгүй хэрэгжих механизм, хөрөнгийн эх үүсвэр нь тодорхойгүй байгаатай холбоотой юм. Товхимол 3 бүлэг, 8 зүйл, дүгнэлт, ном зүй хэсгээс бүрдэнэ.

iii. Хамтын бүтээл - 2

1. Д.Баасансүрэн, О.Хатанболд, Д.Энхболд, А.Хишигдаваа, Ц.Баянмөнх, М.Долгорсүрэн, Ц.Жаргал нар. «Монгол дахь улс төрийн соёл: уламжлал ба орчин үе» Соёмбо принтинг ХХК. Уб, 2020. 29.5 хх



Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» (2017-2019) сэдэвт суурь судалгааны төслийн үр дүн болгож «Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе» хэмээх хамтын бүтээлийг уншигч Танаа толилуулж байна.

Суурь судалгааны төслийн зорилго нь 1990-ээд оноос хойшхи иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, энэ хүрээн дэх бэрхшээл сорилт, тулгамдаж буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулах, иргэдийн улс төрийн соёлыг төлөвшүүлэх арга зам, хэлбэр, шийдлийн зохист хувилбарыг санал болгож, хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулах явдал байв. Судалгааныхаа зорилгыг биелүүлэхийн тулд манай судлаачдын баг Монголын

нийгмийн улс төрийн соёлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг боловсруулж, улмаар улс

төрийн соёлын талаарх орчин үеийн онолд тулгуурлан дүгнэлт гаргах, таамаглалаа шалгах, онолын шинжтэй шинэ санаа дэвшүүлэхийг зорьсон болно.

«Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг» сэдэвт суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд Улаанбаатар хотын 6 дүүрэг болон Дундговь, Дорнод, Орхон, Сэлэнгэ, Ховд аймгуудын 1039 иргэдийн дунд олон нийтийн санаа бодлын судалгааг зохион байгуулж, «Монголын улс төрийн үйл явцын хөгжилд үзүүлэх эдийн засаг, засаглалын зохистой нөлөөллийн асуудал» сэдэвт эрдэм шинжилгээний бичил судалгааг хэрэгжүүлж, «Өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага» сэдэвт экспертийн судалгаа, (40 орчим экспертийн дунд) чанарын судалгааг тус тус зохион байгуулж, гарсан үр дүн, судалгааны шинэлэг тоо баримт, үнэлэлт, санал дүгнэлт зэрэгт тулгуурлан энэхүү хамтын бүтээлийг туурвилаа.

Судалгааны багийн гишүүд эл хамтын бүтээлийг бичихдээ Монгол дахь улс төрийн соёлыг түүхэн уламжлал ба орчин үетэй нь харьцуулан авч үзэж, Монголын улс төрийн соёлын өнөөгийн төлөв байдал, улс төрийн соёлын орчин үеийн хэв маяг, нийгмийн үүрэг, үр нөлөө, улс төрийн болон эрх зүйн соёлын харилцан хамаарал, цаашдын хөгжлийн чиг хандлага зэргийг иж бүрэн байдлаар гарган харуулахыг хичээв. Дашрамд тэмдэглэхэд, энэ бүтээл хэдийгээр хамтын бүтээл боловч оролцсон хувь судлаачдын үзэл бодол, байр суурьт хүндэтгэлтэй хандсан болно.

Тус бүтээлийн удиртгал болон «Улс төрийн соёлын онцлог, туршлага, сургамж» хэмээх нэгдүгээр бүлгийн §1, §2-ийг доктор (Ph.D) Д.Баасансүрэн, §3-ийг магистр Ц.Баянмөнх, доктор (Ph.D) О.Эрдэнэчимэг нар, «Монголчуудын улс төрийн соёлын түүхэн уламжлал» хэмээх хоёрдугаар бүлгийн §1, §3-ийг докторант А.Хишигдаваа, §2-ийг докторант А.Хишигдаваа, С.Мягмарсүрэн, «Өнөөгийн Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага, үүрэг, үр нөлөө» хэмээх гуравдугаар бүлгийг доктор (Ph.D) О.Хатанболд, «Монголын улс төрийн соёлын мөн чанар, хэв маяг» хэмээх дөрөвдүгээр бүлгийн §1-ийг доктор (Ph.D) Д.Баасансүрэн, докторант Д.Энхболд §2-ийг докторант М.Долгорсүрэн, магистр Ц.Жаргал, §3-ийг доктор (Ph.D) О.Хатанболд, дүгнэлтийг доктор (Ph.D), Д.Баасансүрэн, О.Хатанболд, зөвлөмжийг доктор (Ph.D) О.Хатанболд, докторант Д.Энхболд нар тус тус бичсэн болно.

Мөн бидний бүтээлд МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн зөвлөх, доктор (Ph.D), профессор Ц.Ганболд, ШУТИС-ийн Бизнесын удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн НУС-ын эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор Я.Төгөлдөр нар шүүмж өгсөн болно.

2.Хатанболд О, Хишигдаваа А. «Монгол Улс дахь христ итгэлт байгууллагууд» газрын зураг. Уб., 2019

